

# **ТӨРИЙН ЦАХИМ ХАРИЛЦААНЫ ТУХАЙ ХУУЛЬ БОЛОВСРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

## **НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ**

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 47 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого 2017-2025” бодлогын баримт бичиг, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүний үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан “Төрийн цахим харилцааны тухай хууль”-ийн төсөл боловсруулах зорилтын хүрээнд “Хууль тогтоомжийн тухай” хууль болон ЗГ-ын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачилал”-ын дагуу Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас цахим засгийн хөгжлийн асуудалд дүн шинжилгээ хийж дараах үйл ажиллагааг хэрэгжүүллээ. Үүнд:

- Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлох,
- Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдийг тогтоох,
- Асуудлыг үүсгэж буй учир шалтгааныг тогтоох
  - a. Төрийн цахим хэлбэрийн үйлчилгээ, цахим мэдээлэл солилцох, байгууллага хоорондын цахим харилцаа хууль зүйн хувьд хүчин төгөлдөр бус байна;
  - b. Үйлчилгээ, үйл ажиллагаа, бусад байгууллагатай харилцах харилцаагаа цахим хэлбэрээр явуулах, цахим технологийг дэмжих чиг үүрэг төрийн байгууллагууд хуулиар олгогдоогүй байна.
  - c. Технологийн хүчин зүйлийг хүлээн зөвшөөрөх: төрийн байгууллагуудад нийтлэг ашиглах суурь системүүд, тухайлбал, төрийн цахим мэдээлэл солилцооны систем, төрийн онлайн үйлчилгээний портал суваг (вэб болон мобайл аль алиныг оролцуулаад)
  - d. Удирдлага, манлайлал, кросс секторын зохицуулалт үгүйлэгдэж байна.

### **1.1. АСУУДЛЫН МӨН ЧАНАР, ЦАР ХҮРЭЭГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ**

Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлохдоо Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, УИХ-ын тогтоол, төр засгаас төрийн цахим харилцаа, цахим засгийг хөгжүүлэх чиглэлээр 2000 оноос хойш хэрэгжүүлсэн бодлого, хөтөлбөр, арга

хэмжээний тайлан, үр дүн, тэдгээр хөтөлбөрүүдийн хүрээнд хэрэгжүүлсэн томоохон төслүүдийн үр дүн, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Нийслэлийн Мэдээллийн технологийн газар, олон улсын байгууллагаас гаргасан судалгаа, салбарын хэмжээнд зохион байгуулсан хурал, семинараас гарсан зөвлөмж, холбогдох бусад эрдэм шинжилгээ, судалгааны материалыг ашиглалаа.

**Хууль эрх зүйн өнөөгийн байдал.** Монгол Улсын төрийн мэдээллийн харилцааны эрх зүйн тулгуур баримт бичиг нь “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.6. зүйл бөгөөд төрийн мэдээлэл, мэдээллийн сан, дэд бүтцийн талаар дараах заалтууд орсон. Үүнд:

3.6.1.1.үндэсний аюулгүй байдлыг хангах, улс орны хөгжлийг дэмжих, үндэсний үнэт зүйлийг хэвшүүлэх, нийгмийн оюун санааг төлөвшүүлэхэд мэдээлэл, мэдээллийн аюулгүй байдал нэн чухал ач холбогдолтой.

3.6.1.3.үндэсний мэдээллийн дэд бүтцэд халдах аюулаас хамгаалах, эдийн засаг, нийгмийн чадавхийг сулруулах оролдлоготой тэмцэх чадавхийг бий болгоно.

3.6.1.8.мэдээллийн аюулгүй байдлын орчин үеийн дэвшилтэт, өртөг багатай шийдлийг зөвхөн эрсдэлийн үнэлгээний үндсэн дээр сонгон ашиглана. Төрийн байгууллага, онц чухал дэд бүтцийн объектын мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг өндөр түвшинд бэлтгэгдэж, итгэмжлэгдсэн үндэсний мэргэжилтнээр гүйцэтгүүлнэ.

3.6.1.9.өрсөлдөх чадвартай мэдээлэл, харилцаа холбооны систем, техник хэрэгсэл, программ хангамжийн үндэсний үйлдвэрлэл болон мэдээллийн аюулгүй байдлын шийдэл боловсруулах ажиллагааг дэмжин хөгжүүлж технологийн хараат байдлыг бууруулна.

3.6.2.2.төрийн мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хангахын тулд үнэн, бодитой, цаг үеэ олсон, шаардлагатай мэдээллийг төрийн мэдээллийн санд төвлөрүүлж, эрх бүхий этгээд хамтран ашиглах, солилцох нөхцөлийг бүрдүүлнэ.

3.6.2.4.үндэсний мэдээллийн орчин, дэд бүтцийн эмзэг байдлыг бууруулах тогтолцоог бүрдүүлнэ.

3.6.3.3.төрийн өгөгдөл мэдээллийг ангилж, үнэ цэнийг тогтоох, бүртгэх, хадгалах, дамжуулах, шилжүүлэх, хяналт тавих эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгож мөрдөнө.

3.6.3.6.төрийн байгууллага, онц чухал дэд бүтцийн объектын цахим өгөгдлийг дамжуулах, хадгалахдаа шифрлэлт, тоон гарын үсэг, аюулгүй холболт ашиглана.

3.6.4.1.хуулиар хориглоогүй мэдээллийг чөлөөтэй хайх, олж авах, үүсгэх, дамжуулах, түгээх эрх, эрх чөлөөг хангах, мэдээллийн дэд бүтэц, түүний бүрдэл хэсэг,

үйлчилгээнд чөлөөтэй хандах боломжийг бүрдүүлснээр мэдээллийн хүртээмжтэй байдал хангагдана.

3.6.4.3.”...төрийн мэдээллийн нээлттэй нөөцийг бүрдүүлэх ажиллагааг эрчимжүүлж, тэдгээрийг цахим засгийн үйлчилгээнд үр нөлөөтэй ашиглах боломжийг бүрдүүлнэ.”

3.6.4.4.нийгэмд мэдээллийг хүртээмжтэй, түргэн, шуурхай хүргэх мэдээллийн хэрэгсэл, дэд бүтцийн хөгжлийг дэмжиж найдвартай ажиллагааг хангана.

“Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын дээрх заалтууд нь дараах чиглэлүүдэд дахин ангилж болохоор байна. Үүнд:

1. Хууль эрх зүйн зохицуулалт бий болгох;
2. Техник, технологийн шинжтэй арга хэмжээ;
3. Мэдээллийн ашиглалт, хандалт, үнэ цэнийг нэмэгдүүлэх;
4. Тогтолцоо бүрдүүлэх;
5. Боловсон хүчний чадавхийг нэмэгдүүлэх;

	<b>ЧИГЛЭЛ</b>	<b>ЗААЛТ</b>
1.	Хууль эрх зүйн зохицуулалт бий болгох	3.6.1.1,
2.	Техник, технологийн шинжтэй арга хэмжээ	3.6.1.9,
3.	Мэдээллийн ашиглалт, хандалт, үнэ цэнийг нэмэгдүүлэх	3.6.1.1,
4.	Тогтолцоо бүрдүүлэх	
5.	Боловсон хүчний чадавхийг нэмэгдүүлэх	3.6.1.3, 3.6.1.8, 3.6.1.9,

УИХ-ын 2011 оны 61 дүгээр тогтоолын 2 дахь заалтаар “төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхэд шаардлагатай хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж, 2018 оны 54 дүгээр тогтоолын 2 дахь хэсэгт “төрийн мэдээлэл солилцох, түүний аюулгүй байдлыг хангах, өгөгдөл хамгаалах, цахим засгийг бэхжүүлэхтэй холбогдсон эрх зүйн орчныг боловсронгуй болгохтой холбоотой арга хэмжээг судалж танилцуулах” гэж тус тус Засгийн газарт үүрэг болгосон.

Монгол Улсад одоогор хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 154 хуулиар мэдээ, мэдээлэл, мэдээллийн сан, цахим хэлбэр, мэдээллийн систем, сүлжээтэй холбоотой харилцааг зохицуулж байгаа боловч харьцангуй сүүлд баталсан “Бүртгэлийн ерөнхий хууль”-ийн шинэчилсэн найруулгыг эс тооцвол эдгээр хуулийн зонхилох ихэнх хэсэг нь мэдээ, мэдээллийг хэрхэн үүсгэх, бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж байгаа нь зохицуулалтын өрөөсгөл байдал, хууль эрх зүйн дутагдалтай талыг бий болгож байна. Өөрөөр хэлбэл, эдгээр хуулийн зохицуулалтаар төрийн

байгууллагуудад хэрэгжүүлэх чиг үүрэг олгохдоо мэдээлэл, мэдээллийн санг бүрдүүлэхтэй холбоотой харилцааг хуулчилж өгөөд тэдгээр мэдээлэл, мэдээллийн санд хэрхэн хандах, ашиглах, солилцох, нээлттэй болгохтой холбоотой харилцаа болон хэрэгжүүлэх арга замтай холбоотой зохицуулалтыг орхигдуулсан байна.

Харин УИХ-аас 2018 онд баталсан “Бүртгэлийн ерөнхий хууль”-д бүртгэлийн мэдээллийн сан, нэгдсэн, улсын бүртгэлийн цахим сан, тэдгээр сангийн мэдээллийг ашиглах, лавлагаа, мэдээллийг цахим хэлбэрээр олгох, төрийн болон бусад байгууллагатай цахим хэлбэрээр мэдээлэл солилцохтой холбоог нарийвчлан зохицуулж өгсөн нь давуу тал болсон. Гэвч, уг хуулийн 12.12-д төрийн болон бусад байгууллагатай цахим хэлбэрээр мэдээлэл солилцох, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журмыг Засгийн газар батлаж байгаа нь зөв боловч илүү ерөнхий, нийт төрийн байгууллагуудад хамаарах, нийтлэг шинжтэй харилцааг бүртгэлийн чиглэлийн мэдээллийн сангийн зохицуулалтад тусгасан нь төрийн цахим харилцааны жигд, эрх тэгш байдал, төрийн байгууллагуудын жигд оролцоог хангах зарчимд нийцэхгүй байх, мэдээлэл бүрдүүлсэн байгууллага давуу байр суурь, эрх эдлэх хандлага бий болгох талтай, оновчтой бус зохицуулалт болсон. Тийм учраас төрийн болон бусад байгууллагуудтай мэдээлэл солилцох харилцааг нийт оролцогч байгууллагуудын эрх тэгш, жигд оролцоог хангах, төрийн цахим харилцаанд ямар нэгэн байгууллага давамгайл байдал үүсгэх, шударга бус, тэгш бус байдал бий болгохоос зайлсхийсэн зохицуулалт бий болгох шаардлагатай байна.

“Харилцаа холбооны хууль”-д мэдээллийн технологийг гэж компьютер, харилцаа холбооны сүлжээ ашиглан цахим өгөгдлийг үүсгэх, боловсруулах, хадгалах, дамжуулах, солилцох, үйлчилгээ үзүүлэх, бусад тоног төхөөрөмжтэй холбогдох, тэдгээрийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг гэж тодорхойлсон ба мэдээллийн технологийн эрдэмтэн судлаачид, мэргэжилтнүүдийн тогтоосноор мэдээлэл, мэдээллийн сан нь үүсгэх, боловсруулах, хадгалах, дамжуулах, солилцох, архивлах, мэдээлэл, мэдээллийн сангийн тээгчийг устгах гэсэн үе шат, мөчлөгүүдтэй бөгөөд үе шат бүрт хамгаалалт, аюулгүй байдлыг хангах шаардлага тавигддаг байна.

Төрийн мэдээллийг ашиглах харилцааг “Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай” бие даасан хуулиар зохицуулж байгаа боловч уг хуулийн зохицуулалт нь төрийн байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөцийн мэдээллийг ил тод байлгах, тэдгээр мэдээллийг вэб сайтдаа нийтлэх харилцаагаар, “Шилэн дансны тухай хууль”-аар төрийн байгууллагуудын төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах, тэдгээртэй холбоотой мэдээллийг ил тод, нээлттэй байх харилцааг тус тус зохицуулж байгаа нь төрийн байгууллага үйл

ажиллагаа, үйлчилгээгээ цахим хэлбэрээр эрхлэн явуулах, өөр хоорондоо болон иргэн, хуулийн этгээдтэй цахимаар харилцах харилцааг хамарч чадахгүй байна.

Төрийн байгууллагууд дотооддоо цахимжиж, компьютер, мэдээллийн систем ашигладаг болоод багагүй хугацаа өнгөрч байгаа ч тухайн байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагаатай хэрхэн уялдаж нийцэж байгаа, дэмжиж байгаа талаар тайлан, мэдээлэл дутмаг байна. Төрийн байгууллагуудын мэдээллийн сан, системийн ач холбогдол, үнэ цэнийг тогтоож, стратегийн объект гэдэг талаас тодорхойлсон, байгууллагын хуулиар тогтоосон чиг үүргийн хэрэгсэл гэж эрх зүйн байдлыг тодорхойлсон зохицуулалт одоогоор байхгүй байна. Төрийн байгууллагын цахим харилцаа, мэдээллийн технологий асуудал тухайн байгууллагын удирдах, шийдвэр гаргах түвшиний албан тушаалтанд хамаарах зохицуулалт байхгүй байгаа ба мэдээллийн технологи хариуцсан албан хаагчийн ажлын чиг үүргээр тодорхойлогдож байгаа нь “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын холбогдох зорилт, заалт болон төрийн байгууллагуудын цахимжилтын чиг хандлага, шаардлагад нийцэхгүй байна.

УИХ-аас 2011 онд баталсан “Цахим гарын үсгийн тухай хууль”-аар цахим болон тоон гарын үсгийг хэрэглэх эрх зүйн үндсийг тодорхойлж, тоон гарын үсгийн нийтийн түлхүүрийн дэд бүтцийг бий болгохтой холбогдсон харилцааг зохицуулж байгаа ба тэдгээрийн гол хэрэглээ болсон цахим орчны танилт, баталгаажуулалт, цахим баримт бичгийн эрх зүйн үндэс ба түүний цаасан суурьтай баримт бичигтэй эрх зүйн ижил тэнцүү чадамжтай байх, имэйл, компьютерийн файл, гар утас болон социал сүлжээний мэдээ, мэдээллийн сангийн өгөгдлийг нотлох баримт, хууль зүйн чадамжтай баримт гэж үзэх, цахим орчны гэрээ, хэлцэл зэрэг өргөн олон харилцааны хууль зүйн зохицуулалтгүй байна.

Түүнчлэн, УИХ-аас 2017 онд баталсан “Төрийн албаны тухай хууль”-ийн “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүрэг” гэсэн 37 дугаар зүйлийн 37.1.12 хэсэгт “төрийн үйлчилгээг чирэгдэлгүйгээр чанартай, хүртээмжтэй, шуурхай, соёлтой хүргэх, төрийн үйлчилгээг хүргэхдээ аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байх” гэсэн заалт нь төрийн үйлчилгээ, үйл ажиллагаанд инноваци, технологийн дэвшлийг нэвтрүүлсний үр дүнд бүрэн хэрэгжих зохицуулалт гэж үзэхээр байна.

**Иргэдийн хүлээлт.** Монгол Улсад мэдээллийн технологи, интернэтэд суурилсан онлайн үйлчилгээ, төрөл цахим хэрэглээ бий болж төлөвшөөд багагүй хугацаа өнгөрсөн. Монгол Улсад мобайл болон интернэт банкны үйлчилгээ 2002 оноос нэвтэрч хэрэглэгчдийн өргөн ашигладаг мэдээллийн технологийн түгээмэл хэрэглээний нэг болсон. Бизнесийн олон үйлчилгээ, тухайлбал, онгоцны билетийн захиалга, онлайн худалдаа, зорчигч тээвэр, үзвэр үйлчилгээний салбарт онлайн үйлчилгээний хэлбэр нэвтэрч олон түмний хэрэглээ болоод байна. Төрийн зарим үйлчилгээ тухайлбал,

автомашины татвар, хураамжийн төлбөр, татварын тайлан цахим хэлбэрээр илгээх зэрэг үйлчилгээ онлайн хэлбэрт шилжээд байна. Мэдээлэл, харилцаа холбооны салбарт гарсан эдгээр хөгжил, дэвшил нь цаг хугацаа, орон зайнаас үл хамааран үйлчилгээ авах, зардал, цаг хугацаа хэмнэх олон давуу талыг хэрэглэгчдэд мэдрүүлсэн. Энэ нөхцөл байдал нь улмаар төрийн бүх үйлчилгээг онлайн хэлбэрээр авах эрэлт, хүсэлт, хүлээлтийг иргэдийн дунд бий болгож бий болгож байна. */Нийслэлийн засаг даргын тамгийн газраас 2013 онд явуулсан "Төрийн үйлчилгээг онлайн болгох техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах" зөвлөх үйлчилгээний судалгаа/*. Энэхүү эрэлт нь төрийн байгууллагууд өөр хоорондоо цахим хэлбэрээр харилцах, цахим мэдээлэл солилцох, иргэд, байгууллагатай цахим хэлбэрээр харилцах, төрийн үйл ажиллагаа бүхэлдээ цахим хэлбэрт шилжих шаардлагатайг харуулж байна.

**Төр засгаас хэрэгжүүлсэн бодлого, арга хэмжээний үр дүн.** Монгол Улсын төр засгаас мэдээлэл, харилцаа холбооны технологи, түүний дотор цахим засгийг хөгжүүлэх чиглэлээр тодорхой бодлого, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ авч хэрэгжүүлж ирсэн.

Монгол Улсын Их Хурлаас 2000 онд “Мэдээлэл, холбооны технологийг 2010 он хүртэл хөгжүүлэх үзэл баримтлал” (1999-2010), Засгийн газраас 2002 онд “Монгол Улсын мэдээлэл, холбооны технологийг хөгжүүлэх дунд хугацааны стратеги” (2002-2006), 2005 онд “Цахим Монгол үндэсний хөтөлбөр” (2005-2012), 2008 онд “Монгол Улсад бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөр” (2008-2012), 2010 онд “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр” (2010-2015), “Өндөр хурдны өргөн зурвасын сүлжээ үндэсний хөтөлбөр” (2011-2015), 2012 онд “Цахим засаг үндэсний хөтөлбөр” (2012-2016), 2017 онд “Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого” (2017-2025), “Гурван тулгуурт хөгжлийн бодлого” (2018-2020), “Цахим засаглал үндэсний хөтөлбөр”-ийг тус тус батлан хэрэгжүүлсэн буюу хэрэгжүүлж байна.

Дээрх бодлого, хөтөлбөрийн хүрээнд цахим засгийн хөгжилд түлхүү хамааралтай дараах томоохон төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн. Үүнд:

1. Үндэсний дата төв төсөл. Монгол Улсын ЗГ-аас 2006-2012 онуудад хэрэгжүүлсэн “Цахим монгол үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд цахим засгийн чиглэлээр хэрэгжүүлсэн томоохон төслийн нэг нь төрийн мэдээллийн сан ба мэдээллийн технологийн найдвартай байдал, аюулгүй ажиллагааны орчин, дэд бүтэц бий болгох үүрэг бүхий үндэсний дата төвийг байгуулж ашиглалтад оруулсан. Уг төв ашиглалтад орсоноор 2018 оны эхний хагас жилийн байдлаар төрийн 37 байгууллагын мэдээллийн санг төвлөрүүлсэний дээр төрийн байгууллагуудын нийт 211 суурь

үйлчилгээ (сервис) гаргаж байгаа ба цаашид энэ тоог 2000 хүртэл өргөжүүлэх технологийн боломжийг бүрдүүлсэн.

2. Иргэний цахим үнэмлэх төсөл. Монгол Улсын ЗГ-аас 2008-2012 онуудад хэрэгжүүлсэн “Бүртгэлийн нэгдсэн тогтолцоо бий болгох үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлсэн томоохон төслийн нэг нь “Иргэний цахим үнэмлэх” төсөл байсан. Энэ төслийн гол ач холбогдол нь иргэний цахим үнэмлэхэд суусан бичил схем (chip)-д тухайн иргэний тоон гарын үсэг суулгах замаар цахим орчинд иргэнийг адилтган таних боломжийг бүрдүүлсэн. Энэхүү техникийн боломж нь төрийн болон бусад үйлчилгээг интернэтээр дамжуулан цахим хэлбэрээр авах, цахим орчинд төрийн бизнесийн байгууллагатай харилцах боломжийг нээж өгсөн.

3. 11-11 төв. Монгол Улсын Засгийн газраас 2013 онд хэрэгжүүлсэн “Иргэдэд үйлчлэх 11-11 төв” төсөл нь төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэд төрийн байгууллагад хандан өөрсдийн дуу хоолой, санал, гомдлоо хүргэх арга зам болсны дээр төрийн байгууллагуудын хариуцлагатай, нээлттэй болгох, шуурхай байдлыг нэмэгдүүлэх хөшүүрэг болсон чухал арга хэмжээ болсон болно.

4. Нийтийн түлхүүрийн дэд бүтэц. “Цахим гарын үсгийн тухай хууль”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх, цахим орчинд иргэнийг адилтган таних, төрийн болон хувийн хэвшлийн онлайн, цахим үйлчилгээ хөгжихэд найдвартай, аюулгүй орчин бий болгох зорилго бүхий “Нийтийн түлхүүрийн дэд бүтэц” төслийг 2014 онд хэрэгжүүлж ашиглалтад оруулсан. Одоогийн байдлаар тоон гарын үсгийн гэрчилгээ олгох тусгай зөвшөөрлийг 4 аж ахуй нэгжид олгосон ба 2019 оны жилийн эцсийн байдлаар нийт 15000 тоон гарын үсгийн аж ахуйн нэгжид олгогдож татвар, нийгмийн даатгал, төрийн худалдан авах үйлчилгээнд ашиглаж байна.

5. Төрийн үйлчилгээний ТҮЦ машин. Төрийн байгууллагаас иргэд, олон нийт үйлчилгээ авахад шаардлагатай бичиг баримт, лавлагааг аль ойр байгаа байршиж байгаа цэгээс авч цаг хугацаа хэмнэх, иргэдэд учруулдаг зардал, чирэгдэл, хүнд суртлыг багасгахад чухал нөлөөтэй төсөл болсон. Төрийн үйлчилгээний суваг нэг чиглэлийн хэлбэртэйгээр үйл ажиллагаа явуулж буй энэхүү төсөл нь төрийн үйлчилгээний ажилтны чиг үүргийг технологиор сольж дэвшилтэд хэлбэрийн төсөл болсны дээр иргэдийн зүгээс өндөр үнэлгээ авч байгаа арга хэмжээ болсон.

6. Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем. Төрийн байгууллагууд харилцан мэдээлэл солилцох ажиллагааг түргэн шуурхай болгох, хялбаршуулах, байгууллага бүр харилцан гэрээ байгуулж мэдээлэл солилцож байгаа арга, хэлбэрийг халж мэдээллийн технологид (Enterprise Service Bus, ESB) суурилсан мэдээлэл солилцооны дэвшилтэт хэлбэрийг нэвтрүүлсэн шийдэл нь төрийн мэдээлэл солилцооны “ХУР”

систем юм. Уг системийг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Үндэсний дата төв УТҮГ-ын мэргэжилтнүүд хамтран боловсруулсан ба Засгийн газрын 2017 оны 159 тогтоол хэрэгжих боломжийг бүрдүүлсэн болно.

7. Танилт нэвтрэлтийн ДАН систем. Үйлчлүүлэгч иргэн төрийн байгууллагуудын цахим үйлчилгээ тус бүрт бүртгэл үүсгэн, нууц үг авах шаардлагагүйгээр нэгдсэн танилт нэвтрэлтийн эрхтэй болсоноор цахим орчинд бүхий л төрлийн цахим үйлчилгээг авах, төрийн байгууллагуудад байгаа өөрийн мэдээлэлтэй танилцах боломжийг бүрдүүлж буй төрийн цахим үйлчилгээний суурь технологийн платформуудын нэгэн шийдэл нь танилт нэвтрэлтийн “ДАН” систем юм. Тус систем нь төрийн цахим үйлчилгээний ХУР, нийтийн түлхүүрийн дэд бүтцийн системүүдтэй холбогдож ажилладаг ба төрийн үйлчилгээний хүртээмж, үр ашиг, төрийн байгууллагуудын бүтээмжийг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой суурь системийн нэг нь болно.

8. Төрийн үйлчилгээний нэгдсэн төв (ТҮНТ/НҮНТ). Засгийн газрын 2015 оны 141 дүгээр тогтоолоор төрийн үйлчилгээг нэг цэгээс үзүүлэх, Төрийн үйлчилгээний нэгдсэн төв (ТҮНТ) байгуулахаар шийдвэрлэж нийслэл Улаанбаатар хотод 4 төв, 21 аймгийн төвүүдэд төрийн үйлчилгээний нэгдсэн төв байгуулагдан иргэдэд үйлчилгээ үзүүлж байна.

9. Цахим засаг үндэсний хөтөлбөр. Монгол Улсын Засгийн газраас 2011-2015 онуудад “Цахим засаг үндэсний хөтөлбөр”-ийг 4 үндсэн зорилтын хүрээнд хэрэгжүүлсэнээс 129 арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр төлөвлөж хэрэгжүүлсэн. Тус хөтөлбөрийн зорилтууд 25-аас 60 хувийн биелэлттэй гарсан нь хангалттай бус үзүүлэлт болно.


**Цахим засгийн хөгжлийн түвшин.** Монгол Улсын цахим засгийн хөгжлийн үзүүлэлт дээр дурдсан төсөл, арга хэмжээ, төрийн цахим үйлчилгээ, харилцааны суурь систем болох ХУР, ДАН системүүдийг хөгжүүлж нэвтрүүлсэн үр дүнд дэлхийн дундаж хэмжээнд хүрч цахим засгийн хөгжлийн үе шатны төлөөлөл түвшинд хүрсэн ба цаашид иргэн төвтэй, цахим засгийн зааггүй буюу шилжилт түвшинд шилжих шаардлагатай байна.

Олон улсын түвшинд цахим засгийн хөгжлийн үзүүлэлтийг харж болох эх үүсвэр нь НҮБ-аас 2 жил тутам гаргадаг “НҮБ-ийн цахим засгийн судалгаа” болно. (<https://publicadministration.un.org/egovkb>).


Энэхүү судалгааны үр дүнгээс харахад Монгол Улсын цахим засгийн хөгжлийн үзүүлэлтээр бусад улс орноос хоцрогдох явдал хадгалагдаж байгааг харж болно. Өөрөөр хэлбэл, цахим засаглалын хөгжлийн үзүүлэлтээр Монгол Улсын индекс буураагүй, өсөлттэй гарч байгаа ч дэлхийн 190 гаруй орнуудын дунд эзлэх байр



сүүлийн жилүүдэд ухарсаар 2018 он гэхэд 92 дугаарт орж байгаа нь бусад улс орнууд биднээс илүү эрчимтэй ажиллаж, үр дүнд хүрч байгааг илтгэж байна (Зур-1).




Зур-1. а). Монгол Улсын цахим засгийн хөгжлийн индекс



Зур-1. б). Монгол Улсын цахим засгийн хөгжлийн үзүүлэлтээр 190 орны дунд эзэлсэн байр

Тухайлбал, Казахстан, Узбекистан, Киргизстан, Азербайджан зэрэг ТУХН орнууд улсууд, Тайланд, Индонез зэрэг Азийн бүсийн улс орнууд цахим засгаа хөгжүүлэх чиглэлээр ахиц дэвшил гаргаж чадсан. ТУХН-ийн орнууд цахим засгийн хөгжлөөр тэргүүлэгч Эстони улсын загварыг нутагшуулах, тэргүүн туршлага шийдлийг нэвтрүүлэх, цахим засгийн удирдлагын тогтолцоо бүрдүүлсэн нь үзүүлэлтээ ахиулах нөхцөл, шалтгаан болсон. Эдгээр улсууд Эстони улсын төрийн мэдээлэл солилцооны X-Road системийг нэвтрүүлж өөрсдийн төрийн үйлчилгээний бренд системийг бий болгоод байна. Тухайлбал, Киргиз, Азербайджан, Узбек зэрэг улсууд өөрсдийн хөгжүүлсэн системтэй болоод байна. Нөгөө талаар эдгээр улсууд цахим засгийн

хөгжил хариуцсан бүтэц байгуулсан нь хөгжлийн үзүүлэлтэд ахиц гарахад нөлөөлсөн байна.



Зураг 1: НҮБ-ийн цахим засгийн хөгжлийн тайлан, Монгол Улсын үзүүлэлт

### Цахим засгийн чиглэлээр олон улсын байгууллагаас хийсэн судалгаа.

Цахим засгийн хөгжлийн чиглэлээр нэр хүнд бүхий олон улсын байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагаас янз бүрийн цаг хугацааны туршид олон талын судалгаа, тайлан, нийтлэл гарсан. Тухайлбал:

1. НҮБ-аас дэлхийн улс орнуудын цахим засгийн хөгжлийн үзүүлэлтийг хоёр жил тутам үнэлж “НҮБ-ын цахим засгийн хөгжлийн тайлан” гаргадаг. Түүнчлэн, Дэлхийн банк, Гартнер, Лайне & Ли зэрэг олон улсын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагаас цахим засгийн чиглэлээр төрөл бүрийн судалгаа явуулж нийтлэл, тайлан, илтгэлд гаргадаг.
2. Дээр дурдсан байгууллагуудаас тогтоосноор цахим засгийн хөгжлийн түвшин, үе шатыг дараах хэд хэдэн үе шатад хувааж үзэж байна. Үүнд:

Эх сурвалж Түвшин	НҮБ/АСПА	Дэлхийн банк	Гартнер	Лайне & Ли
Хандалт	Шинэ тутам (Emerging) Өргөтгөсөн (Extended)	Нийтлэл (Publish)	Төлөөлөл (Presence)	Каталог (Catalogue)
Харилцах	Харилцах (Interaction)	Харилцах	Харилцах	
Транзакци	Транзакци (transaction)	Транзакци	Транзакци	Транзакци
Интеграци	Зааггүй (seamless)		Шилжилт (Transformation)	Босоо интеграци Хэвтээ

3. Цахим засгийн хөгжил нь техник технологийн арга олон хүчин зүйлийн нэгдэл, оролцогч талуудын хамтын ажиллагаа

Судалгааны байгууллагуудаас гаргасан тайланд цахим засгийн хөгжлийн асуудал нь удирдлагын манлайлал (*management leadership*), төрийн байгууллагуудын жигд оролцоог шаардсан (*whole-of-government approach*) олон хүчин зүйл, олон үе шат, түвшинтэй, нийгэм-технологийн байнгийн тасралтгүй процесс гэж тодорхойлсон.

Нөгөө талаар, гадаа улс орны эрдэм шинжилгээ судалгааны байгууллагуудаас цахим засгийн хөгжил, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлох чиглэлээр үлэмж хэмжээний шинжлэх ухааны судалгааны ажлууд хийгджээ. Эдгээр судалгаа, эрдэм шинжилгээний нийтлүүдэд онцолсоноор цахим засгийн хөгжил нийгэм-удирдлага-технологийн аспект бөгөөд технологийн хүчин зүйл ба удирдлага, бүтэц, тогтолцоо, тэдгээрийн үйл ажиллагаа, тэнд ажилладаг хүмүүсийн харилцан нөлөөллийн үр дүн байна гэж томъёолсон байна.

**Цахим засгийн чиглэлээр хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл.** УИХ-ын Цахим бодлогын түр хороо, ЗГХЭГ-аас 2018 онд явуулсан судалгаагаар төрийн нийт 15 байгууллагууд дээр 897 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 71 төсөл хэрэгжиж байсан бол 2020 оны 1 дүгээр сарын байдлаар нийт 1 тэрбум гаруй төгрөгийн мөнгө дүн бүхий төсөл хэрэгжиж байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 170 дугаар захирамжаар байгуулсан Мэдээлэл, харилцаа холбооны бодлогын зөвлөлийн 3 дугаар хурлаас төрийн байгууллагуудад цахим засгийн чиглэлээр улсын төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний явцын байдал, хэрэгжилтийн талаар судлаж нэгтгэх, давхардлыг илрүүлэх, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх санал боловсруулах чиглэлийн дагуу 13 яам, Үндэсний хөгжлийн газар, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Монгол банк болон Нийслэлийн Мэдээллийн технологийн газар, Гааль татвар санхүүгийн мэдээллийн технологийн төв УҮГ-т хэрэгжиж байгаа болон хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсөл, арга хэмжээнүүдийг талаар судлагаа явуулж тайлан гарсан. Уг судалгаанд Эрчим хүчний яамны зүгээс тухайн салбарт мэдээллийн технологийн чиглэлээр хэрэгжиж байгаа болон хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээ байхгүй, Батлан хамгаалах яамнаас дээрх чиглэлээр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээ нь нууцын зэрэглэлд хамаарах судалгаанд мэдээлэл гаргаж өгөх боломжгүй гэсэн бол Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хариу өгөөгүй болно.

**Төслийн тоо, хэмжээ:** Уг судалгааны тайлангаас үзвэл улсын төсөв, гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр **71 төсөл** хэрэгжиж байгаа ба тэдгээрт **897** (+16 сая зээлжих эрх) **тэрбум** төгрөгийг эдийн засаг, нийгмийн салбарт мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэхээр хэрэгжүүлж байгаа буюу хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Төслүүдийг салбар тус бүрээр авч үзвэл барилга, хот байгуулалтын

яам – 12, зам тээврийн хөгжлийн яам – 12, боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам – 4, хууль зүй дотоод хэргийн яам – 8, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам – 1, уул уурхай, хүнд үйлдвэрийн яам – 5, байгаль орчин, аялал жуулчлалын яам – 2, гадаад харилцааны яам – 1, эрүүл мэндийн яам – 3, сангийн яам – 10, Монгол банк – 1, Үндэсний хөгжлийн газар – 1, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар – 3, Нийслэлийн Мэдээллийн технологийн газар – 7, ЗГХЭГ – 1 тус тус хэрэгжиж байгаа буюу хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хэрэгжиж байгаа мэдээллийн технологийн **56 төсөл**, арга хэмжээний үнийн дүнг хөрөнгө оруулалтаар нь ангилбал **улсын төсвөөс** 17.8 тэрбум төгрөг, **гадаадын хөнгөлөлттэй зээлээр** 519.5 тэрбум төгрөг, **буцалтгүй тусламжийн** 70.5 тэрбум төгрөг, **сангийн хөрөнгө** 167.3 тэрбум төгрөг, **нийслэлийн төсвөөс** 1.7 тэрбум төгрөгийг төсөвлөсөн байна.

Хэрэгжүүлэхээр төлөвлөөд байгаа мэдээллийн технологийн 15 төсөл, арга хэмжээний үнийн дүнг хөрөнгө оруулалтаар нь ангилбал **улсын төсвөөс** 14.8 тэрбум төгрөг, **гадаадын зээлээр** 105.4 тэрбум төгрөгийг төсөвлөсөн байна.

**Хэрэгжилтийн явц:** Төслийн хэрэгжилтийн явцыг одоогоор үнэлэх боломжгүй, хэрэгжилтэд хяналт хийгдээгүй 25 төсөл, тендерийн бичиг баримт боловсруулах, сонгон шалгаруулалт зарласан, дуусаагүй хэрэгжилт зэрэг 20 хүртэлх хувийн хэрэгжилттэй 21 төсөл, 81 хувиас дээш хэрэгжилттэй 9 төсөл, арга хэмжээ байна. Мөн гэрээнд тусгагдсан хэрэгжүүлэх хугацаа нь дууссан боловч хөгжүүлэлт нь дуусаагүй төслүүд байна.

**Төслийн давхардал:** Давхардаж байгаа нийт 14 төсөл, тэдгээрийн үнийн дүн 104.269 тэрбум төгрөг байна. Энэ үнийн дүнд тухайн төслийг хэрэгжүүлэх техник, эдийн засгийн үнэлгээний судалгаа боловсруулах, зөвлөх үйлчилгээ, сүлжээ, аюулгүй байдлыг хангах, хадгалах болон дагалдах нэмэлт тоног төхөөрөмжүүдийг худалдан авах зэрэг өртөг шингэсэн бүтэцтэй байна. *Төслийн үнийн задаргаанаас програм хангамж, систем хөгжүүлэлтийн дүнгээр нь давхардаж буй хөрөнгө оруулалтын үнийн дүнг тодорхой гаргах боломжтой байна.*

**Төслийн нэгдсэн удирдлага:** Судалгаанд хамрагдсан 71 төсөл, арга хэмжээ нь нэгдсэн удирдлагагүйгээр хэрэгжиж байна. Түүнчлэн, эдгээр төслүүдийн мэдээллийн нэгдсэн сан байхгүй, төсөл хоорондын уялдаа сул, бусад байгууллагуудтай мэдээлэл солилцох шаардлага тусгагдаагүй байдалтай байна.

**Мэдээллийн системийн хөгжүүлэлтийн ерөнхий чиглэл:** Судалгаанд хамрагдсан төслүүдийн удирдамж болох ямар нэг ерөнхий чиглэлийг аль нэг эрх бүхий байгууллага тогтоосон тохиолдол байхгүй байна. Төрийн байгууллагуудын мэдээллийн систем хөгжүүлэлтэд тавигдах шаардлага, баримтлах ерөнхий чиглэл

байхгүй байгаа нь эдгээр мэдээллийн системүүдийн харилцан нийцэл, хөрөнгө оруулалтын болон үйл ажиллагааны оновчтой шийдлийг тогтоох боломжгүй болгох, нэгдсэн бодлого, төлөвлөлт үгүйлэгдэж байгааг харуулж байна.

**Төслүүдийн ерөнхий үнэлгээ:** Судалгаанд хамрагдсан төслүүдийн тайланг авч үзэхэд дараах дутагдалтай талууд илэрсэн. Үүнд:

- Ихэнх төслүүдийн хэрэгжилт удаашралтай байна.
- Бусад салбарын үйл ажиллагаатай нийцэл, уялдаа холбоотойгоор хийгдэх, мэдээлэл солилцох талаар хийгдээгүй. Төрийн үйл ажиллагааны реинженеринг хийх заалт тусгагдаагүй.
- Төслүүдийн хэлбэр, агуулга нь салбар бүр тус тусдаа, харилцан уялдаагүй, харилцан хамааралгүй явж ирсэн уламжлалт тогтолцоог дэмжсэн байна.
- Төслүүдийн нэгдсэн удирдлага, төлөвлөлт, зохицуулалт, хяналт, аудит шаардлагатай байгааг илтгэж байна. Төслүүд төлөвлөлтгүйгээр хийгдсэн, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг урьдчилан тооцоогүй байна.

#### **ДҮГНЭЛТ:**

Энэхүү шаардлага нь төрийн цахим үйлчилгээ, төрийн байгууллагуудын цахим харилцаанд шаардлагатай суурь үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлох шаардлагатайг илтгэж байна.

Нөгөө талаас УИХ-аас 2011 онд “Цахим гарын үсгийн тухай хууль”-ийг баталж, мөн оны “Цахим гарын үсгийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 61 дүгээр тогтоолоор төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхэд шаардлагатай хуулийн төслийг боловсруулахыг Засгийн газарт үүрэг болгож байсан болно.

Түүнчлэн Засгийн газраас “Цахим Засаг” үндэсний хөтөлбөрийг 2011-2015 онуудад хэрэгжүүлж, 2013 онд 212, 146 дугаар тогтоолуудаар төрийн нэгдсэн цахим өгөгдлийн сан байгуулах, 2016 оны 254, 411 дүгээр тогтоолуудаар төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр хэрэгжүүлэхээр шийдвэрлэж байсан. Гэвч дээрх тогтоол, шийдвэрүүдийн тавьсан зорилго, зорилт бүрэн биелээгүй, зарим тогтоол, шийдвэрүүд хэрэгжихэд хүндрэл, бэрхшээлтэй тулгарч байна.

Төрийн үйлчилгээ, харилцааг цахим хэлбэрээр явуулах, иргэд байгууллагад цахим хэлбэрээр үйлчилгээ хүргэх ажиллагаа удааширч байгаа өнөөгийн байдал нь Монгол Улсын засаглалын чадавхи болон цахим засгийн хөгжлийн үзүүлэлтээр бусад улс орнуудаас хоцрох, МТ-ийн дэвшил, боломжийг бүрэн дүүрэн ашиглаж төрийн үйлчилгээ, үйл ажиллагааг боловсронгуй болгох, улмаар засаглал, нийгэм, эдийн

засгийн хөгжлийг дэмжих, түргэтгэх үйл ажиллагаа хоцрогдолтой байна. Энэ бүхэн нь цаашлаад Монгол Улсын өрсөлдөх чадварыг өсгөх, олон улсын түвшинд эзлэх байр суурийг дээшлэхэд нөлөөлж чадахгүй байна.

## 1.2. ЭРХ, ХУУЛЬ ЁСНЫ АШИГ СОНИРХОЛ НЬ ХӨНДӨГДӨЖ БАЙГАА ЭТГЭЭД

Өмнөх хэсэгт дурдсан асуудал нь дараах бүлгийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд сөргөөр нөлөөлж байна.

	Эрх ашиг нь хөндөгдөж буй бүлэг	Нөлөөлж буй хэлбэр
1.	Иргэд	Төрийн байгууллагуудаас иргэд, байгууллагуудад үзүүлж байгаа үйлчилгээ нь хүнд сурталтай, цаг хугацаа их зарцуулдаг, үйлчилгээний ажилтны харилцаа муу, төрийн бусад байгууллагуудад байгаа мэдээлэл, баримт бичиг бүрдүүлж ирэхийг иргэдээс шаардах зэргээр үйлчлүүлэгчдэд хүндрэл, чирэгдэл учруулж байна. Тухайлбал, <i>(иргэнд үзүүлдэг төрийн зарим үйлчилгээний талаар, цаг хугацааны талаархи жишээ дурдах)</i>
2.	Төрийн байгууллага	Төрийн үйлчилгээ, төрийн байгууллагуудын үйл ажиллагааг цахимжуулах, мэдээллийн технологийн тусламжтай боловсронгуй болгох, иргэн байгууллагатай цахим хэлбэрээр харилцах чиг үүргийг төрийн байгууллагуудад олгоогүй учраас удирдах, шийдвэр гаргах албан тушаалтнуудын түвшинд цахим засаг, төрийн нэгдмэл цахим үйлчилгээний мөн чанар, ач холбогдолын талаарх ойлголт, мэдлэг сул, удирдах албан тушаалтны хувийн үзэмжийн асуудал хэлбэртэй байна. Тухайн байгууллагын цахим харилцааны асуудал нь зөвхөн мэдээллийн технологи хариуцсан албан хаагчийн эрхлэх асуудлын хүрээгээр хязгаарлагдаж байна. Төрийн байгууллагуудын түвшинд цахим засгийн үйл ажиллагааны нэгдсэн удирдлага, төлөвлөлт, хяналтын тогтолцоо байхгүйгээс үүдэн төрийн байгууллагуудын зүгээс хэрэгжүүлж буй цахим засгийн хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, хөгжүүлж буй систем нь тухайн байгууллагын чиг үүргийг бүрэн дэмжихгүй, бусад байгууллагын системтэй харилцан нийцэлтэй байх, харилцан мэдээлэл солилцох шаардлагыг хангахгүй байхын зэрэгцээ гадаад улс орнуудын зээл, тусламжаар хэрэгжүүлж буй төслүүд нь давхардсан хөрөнгө оруулалт болох, хоцрогдсон, үр ашиг муутай технологи нэвтрүүлэхэд хүргэж байна. Төрийн цахим үйлчилгээ, төрийн байгууллагуудын цахим харилцаа, иргэдэд үзүүлэх үйлчилгээндээ инноваци, мэдээллийн технологийн дэвшлийг ашиглаж чадахгүй байгаагаас үүдэн тухайн байгууллагын бүтээмж, үр ашиг хангалтгүй, мэдээллийн технологийн мэдлэг, ур чадвар сул, үйлчилгээний шинэ соёлын төлөвшил муу, ажлын ачаалал их байх, иргэдийн санал, гомдолд өртөх явдал хадгалагдсаар байна.
3.	Төрийн үйлчилгээ авдаг байгууллага	Төрийн үйлчилгээ, төрийн байгууллага хоорондын үйл ажиллагааны сул, цахимжаагүй байгаа нь төрийн үйлчилгээ авдаг байгууллагад цаг хугацаа алдах, төрийн үйлчилгээ авах нэмэлт зардал гарч байна. Нөгөө талаар төрийн үйл ажиллагаа, үйлчилгээний чанар, соёлоос хамааралтай бизнес эрхлэх улс төр, нийгмийн орчин, нөхцөл байдлыг доройтуулж байна.
4.	Монгол Улс	Монгол Улсын хөгжлийн олон үзүүлэлт дэлхийн дунджаас байнга доогуур байна. Тухайлбал, НҮБ-аас гаргадаг “Цахим засгийн хөгжлийн индекс” Дэлхийн банкнаас гаргадаг “Засаглалын чадавхийн индекс”, Транспаренси интернэйшнл байгууллагаас гаргадаг “Авилгалын индекс”, Дэлхийн эдийн засгийн форумас гаргадаг “Өрсөлдөх

		<p>чадварын индекс” зэрэг үзүүлэлтээр Монгол Улсын үзүүлэлт ахиц, дэвшил гарахгүй, зарим үед буурах явдал ажиглагдаж байна. Монгол Улс технологийн дэвшлийг хөгжлийн хөшүүрэг болгож ашиглаж чадахгүй, төрийн үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэхэд ахиц дэвшил муу байна.</p>
--	--	--

### 1.3. АСУУДЛЫГ ҮҮСГЭЖ БУЙ ШАЛТГААН НӨХЦӨЛ

Дээрх мэдээлэл, холбогдох байгууллагуудын тайлан мэдээг нарийвчлан судалж үзсний дүнд дараах асуудлууд байгааг тогтоов:

1. **Цахим мэдээлэл солилцох үйл ажиллагааны тогтолцоо бүрдээгүй байна.** Аль нэг байгууллага дээр бүрдэж бий болсон мэдээллийн сан тухайн байгууллага, эсвэл салбар гэхээсээ илүүтэй бусад иргэн, байгууллагад үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд шаардлагатай байна. Монгол Улсын хэмжээнд мэдээлэл, мэдээллийн сан, цахим систем, сүлжээнд хамаарах зохицуулалт 154 хуулинд тусгагдсан байна. Гэвч эдгээр зохицуулалт нь тухайн байгууллага тэдгээр мэдээлэл, мэдээллийн санг хэрхэн бүрдүүлэх талаар зохицуулсан боловч тэдгээрийг хэрхэн дахин ашиглах, тэдгээрт хандах хандалт, мэдээллийг хүртээмжтэй болгох, байгууллагууд цахим мэдээллийг хэрхэн солилцох, төрийн нээлттэй өгөгдөл бий болгох зохицуулалт хомс байна. Төрийн, эсвэл бизнесийн байгууллагын үйлчилгээ авахад төрийн байгууллагын мэдээллийн санд байгаа мэдээллийг авч ирэхийг иргэдээс шаарддаг. Энэ эрэлт, шаардлагын үүднээс иргэн, хуулийн этгээд төрийн байгууллага тус бүрт хандаж лавлагаа, тодорхойлолт авдаг хэлбэр он удаан жилээр үргэлжилж ирсэн. Төрийн үйлчилгээний энэ уламжлалт хэлбэр нь иргэд, үйлчлүүлэгчдийн цаг завьг барах, төрийн байгууллага дээр хэт их дараалал, ачаалал үүсэх, үйлчилгээний ажилтны соёл болон төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сул байх зэрэг олон хүндрэл, бэрхшээлийг бий болгож байсан. Засгийн газраас уламжлалт энэ арга барилыг халах зорилгоор төрийн үйлчилгээний машин буюу “ТҮЦ” машиныг 2013 оноос, төрийн мэдээлэл солилцооны “ХУР”, танилт нэвтрэлтийн “ДАН” системийг 2017 оноос хэрэгжүүлж байгаа ч энэ нь зөвхөн техник, технологийн түвшинд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ бөгөөд эдгээр системийн гүйцэтгэж байгаа үйл ажиллагааг зохицуулсан зохицуулалт одоогоор хууль зүйн түвшинд байхгүй байна. Төрийн байгууллагуудын үйл ажиллагаа тодорхой хэмжээнд хүрч, нэлээдгүй олон байгууллага мэдээллийн сан бүрдүүлээд байгаа, төрийн цахим мэдээлэл солилцох техник, технологийн боломж бүрдээд байгаа өнөөгийн нөхцөлд үйлчилгээ авахаар хандаж байгаа иргэн, хуулийн этгээдийг төрийн бусад байгууллагад байгаа мэдээлэл, тодорхойлолтоо авч ирэхийг шаардах бус тухайн иргэн, хуулийн этгээдийн хүсэлт, зөвшөөрлөөр мэдээллийг бусад байгууллагын мэдээлэлд хандах, хүсэлт гаргасан

иргэн, хуулийн этгээд төрийн үйлчилгээ авахаар гаргасан хүсэлтийн шийдвэрлэлтийн явцыг хянах боломжтой байх хэлбэрт шилжих шаардлагатай байна. Цахим мэдээлэл солилцох үйл ажиллагааг цогцоор авч үзвэл удирдлага, зохион байгуулалт, хэрэгжүүлэлт, техник технологийн арга хэмжээ, тэдгээрийн аюулгүй байдлыг хангах, энэ харилцаанд хамааралтай байгууллагуудын жигд оролцоог бүрдүүлэхэд чиглэсэн хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх асуудал нэн тэргүүний ач холбогдолтой юм. Тийм учраас, цахим мэдээлэл солилцох үйл ажиллагааны тогтолцооны бүрэлдэхүүн болсон дараах зохицуулалт бий болгохыг шаардаж байна. Үүнд:

- Төрийн үйл ажиллагаа, үйлчилгээ, албан бичиг солилцох харилцаа цахим хэлбэрээр эрхэлж болох хууль зүйн зохицуулалт бий болгох;
- Төрийн цахим харилцааны нэгдсэн удирдлага, зохицуулалт, хяналтын тогтолцоо бүрдүүлэх, төрийн цахим харилцаанд оролцогч болон хэрэгжилт хариуцсан субъектүүдийн үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах хууль зүйн зохицуулалт бий болгох;
- Төрийн цахим харилцааны субъектүүдийн чиг үүргийг тодорхой болгох, цахим засаг, цахим харилцааны талаар захиргааны байгууллагуудын чиг үүргийг тодорхой болгох;
- Төрийн цахим харилцааны техник, технологийн үндэс болсон цахим харилцааны суурь систем, захиргааны байгууллагуудын чиг үүргээр бий болсон мэдээллийн сан, системийн эрх зүйн байдлын тодорхойлох, аюулгүй байдлыг хангах хууль зүйн зохицуулалт бий болгох;

**2. Мэдээллийн сангийн дахин ашиглалт /Reuse, open data, Informed decision – Decision support/.** Төрийн байгууллагын мэдээллийн санд бүртгэгдсэн мэдээлэл нь иргэн, хуулийн этгээдэд хамаарах мэдээлэл боловч иргэний зүгээс тэдгээр мэдээлэлд хандах, төрийн мэдээллийн сан дах өөрийн мэдээлэлтэй танилцах зохицуулалт хуулинд тусгагдаагүй байна. Нөгөө талаар мэдээлэл, дата нь үл шавхагдах нөөц бөгөөд инноваци, шинэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ хөгжиж бий болох хүчин зүйл, өгөгдөл, мэдээлэлд суурилсан эдийн засгийн шинэ сектор үүсч хөгжих хөшүүрэг мөн гэдгийг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч аж үйлдвэрийн 4 дүгээр хувьсгалын суурь нөхцөл гэж үзэж байна. Тийм учраас төрийн мэдээллийн сан, түүний мэдээллийг дахин ашиглах (reuse), төрийн мэдээллийн санг бодлого боловсруулах, түргэн, шуурхай шийдвэр гаргах, төрийн мэдээллийг нээлттэй болгох замаар мэдээллийн технологид суурилсан олон талт бүтээгдэхүүн, үйлчилгээ үүсч хөгжих эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх шаардлагатай байна. Үүний үр дүнд дараах үр дүнд хүрэх боломжтой. Үүнд:



- Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж дээшлэх;
- Төрийн удирдлагын шинэчлэлийн арга механизм бүрдэх;
- Нийгэм, эдийн засгийн засгийн хөгжлийн эх үүсвэр, нөөц бий болох;
- Ардчилал, хүний эрхийн баталгаа, иргэдийн зүгээс төрийн удирдлагын үйл хэрэгт оролцох, хувь нэмрээ оруулах боломж бүрдэх;

3. **Мэдээллийн сан, системийн нэгдсэн бүртгэл, хяналт /::Registration, approval, IT investment and cost control/.**

Мэдээллийн аюулгүй байдлын асуудал нь Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын нэг хэсэг ба өнөөгийн байдлаар төрийн байгууллагуудын үйл ажиллагаа цахимжиж, мэдээллийн сан, систем байгуулах, компьютер, мэдээллийн системийг үйл ажиллагаандаа ашиглах явдал түгээмэл болж байна. Төрийн байгууллагуудын үйл ажиллагаа цахимжихын хэрээр мэдээллийн эмзэг байдал, нууцлал алдагдах эрсдэл нэмэгддэг тул төрийн байгууллагуудын мэдээллийн сан дахь иргэн, хуулийн этгээдийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, тэдний зүй ёсны эрх ашгийг хамгаалах асуудал ёсоор хөндөгдөж байна. Энэ утгаараа төрийн байгууллагуудын мэдээллийн сан, систем нь үндэсний аюулгүй байдалд шууд хамааралтай, зайлшгүй анхаарал тавих ёстой стратегийн онц ач холбогдолтой объект юм. Нөгөө талаар Мурын хуулийн дагуу 1.5 жил тутам бичил схемийн транзисторын тоо 2 дахин нэмэгдэнэ гэсэн таамаг 1960-аад оноос эхлэн дэлхий нийтийн практикт хадгалагдсаар ирсэн бол Аксенчер компаниас 2015 онд гаргасан судалгаагаар төрийн байгууллагууд нь мэдээллийн технологи, инновацийн нөлөөгөөр эрс өөрчлөлт орох салбарын нэг гэж тодорхойлсон. Энэ нь төрийн байгууллагуудын мэдээллийн систем, техник, технологийн хэрэгслүүд богино хугацаанд түргэн шинэчлэгдэх хандлагатай, мэдээллийн сан, системийн төлөвлөлт, хөгжүүлэлтэд хариуцлагатай хандах, зохих ерөнхий шаардлагад нийцүүлэх, төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн төсөл, хөтөлбөрийн харилцан уялдааг хангах, хөрөнгө оруулалт, зардлын удирдлага, хяналтын зохих механизм бүрдүүлэх, шаардлагатай тохиолдолд систем, сан хөгжүүлэх, шинэчлэх ажлыг эрх бүхий байгууллагаар хянаж баталгаажуулах шаардлагатайг харуулж байна. Нөхцөл байдал ийм байхад төрийн байгууллагуудын мэдээллийн сан, системийн нэгдсэн бүртгэл хөтлөх, тэдгээрт хяналт, шалгалт хийсэн болон үнэлгээ, дүгнэлт хийж тайлан, мэдээ гаргах ажил хийгдэхгүй, үрэлгэн, урсгалаар явж байна. Мэдээллийн аюулгүй байдал, иргэд, байгууллагын эрх ашиг, бусад олон талын нийлмэл хүчин зүйлийн нэгдэл болж байгаа мэдээллийн сан, систем, сүлжээг бүртгэлжүүлэх, хөгжүүлэлт, шинэчлэлийг зохих түвшинд нь цаг алдалгүй хийх, үр ашиггүй хөрөнгө оруулалт,

давхардлаас сэргийлэх, ашиглалт, үйлчилгээ болон тооцоолон бодох нөөцийг удирдах, зохистой түвшинг ханган барих, мэдээллийн сан, системийн төлөвлөлт, хөрөнгө оруулалт, зардлыг хянах, бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчид, олон нийтийн зүгээс хяналт тавих, хариуцлагыг дээшлүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

## **ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ**

Аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх зорилгыг дараах байдлаар тодорхойлж байна.

**Асуудлыг шийдвэрлэх зорилго нь** төрийн үйлчилгээний цахим хэлбэр, төрийн байгууллагуудын цахим харилцаа, цахим мэдээлэл болон баримт бичгийн солилцоо, тэдгээрийг хангах суурь систем, төрийн мэдээллийн сан, түүний ашиглалт, нээлттэй өгөгдөл, мэдээллийн систем, сүлжээний эрх зүйн байдлыг тодорхойлох, тэдгээрийн нэгдсэн бүртгэл хөтлөх, хөрөнгө оруулалт, зардал, төсөл, хөтөлбөрийн удирдлага, хяналтыг нэвтрүүлэх, төрийн үйлчилгээ, үйл ажиллагааг инноваци, технологийн тусламжтайгаар боловсронгуй болгох үйл ажиллагааны нэгдсэн удирдлага, төлөвлөлт, хяналтын тогтолцоо бүрдүүлэн иргэн, үйлчлүүлэгч төвтэй төрийн үйлчилгээ, харилцааны дэвшилтэт хэлбэрийг төлөвшүүлэх, төрийн байгууллагуудын үйл ажиллагааг дахин инженерлэх, төрийн удирдлагын шинэчлэл хийх боломжийг бүрдүүлэхэд оршино.

## **ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ**

Өмнөх хэсэгт томъёолсон зорилгыг Аргачлал 5.1-т заасан дараах хувилбаруудын хүрээнд “Зорилгод хүрэх байдал”, “Зардал, үр өгөөжийн харьцаа” гэсэн шалгуур үзүүлэлтүүдийн хүрээнд харьцуулан судлав.

<b>Хувилбар</b>		<b>Зорилгод хүрэх байдал</b>	<b>Зардал, үр өгөөжийн харьцаа</b>	<b>Үр дүн</b>
1.	“Тэг” хувилбар	Энэхүү хувилбарын хувьд зорилгод хүрэх боломжгүй	Зардал гарахгүй ч үр өгөөж байхгүй	Үр дүн сөрөг
2.	Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх	Зорилгод бүрэн хүргэхгүй. Энэ хувилбарыг хэрэглэх зорилгод хүрэх үйл ажиллагаа удаашралтай, төрийн бүх байгууллагуудын ижил тэгш оролцоог хангах боломжгүй.	Тодорхой зардал гарах боловч нийт төрийн байгууллагуудыг жигд хамарсан үр дүнд хүрэхгүй.	Үр дүн сөрөг

3.	Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх	Зорилгод хүрэх боломжгүй	Зардал гаргасан, гаргаагүй аль ч тохиолдолд үр өгөөж гарахгүй, зах зээлийн механизм үйлчлэх боломжгүй.	Үр дүн сөрөг
4.	Төрөөс санхүүгийн интервенц хийх	Төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх тохиолдолд хүний нөөц, техник, технологийг бэхжүүлэх боломжтой ч зорилгыг бүрэн хамарч, тогтвортой түвшинд хүрч чадахгүй.	Тодорхой зардал гарах бөгөөд харин үр өгөөж нь хүний нөөц, техник, технологийг л бэхжүүлнэ.	Үр дүн сөрөг
5.	Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүрэг гүйцэтгүүлэх	Зорилгын тодорхой хэсэг, тухайлбал, төрийн цахим систем, сан, үйлчилгээ хөгжүүлэлт, тэдгээрийн ашиглалт, үйлчилгээ, бэлэн байдлыг хангах зэрэг зарим нэг хэсэгт үр дүнтэй байж болно. Гэвч төрийн үйл ажиллагаа, үйлчилгээ нь тухайн салбарын хууль, тогтоомжоор зохицуулагдаж байдаг тул нийтлэг байдлаар үр дүнд хүрэхэд хангалттай биш.	Тодорхой зардал гарах хэдий ч үр өгөөж нь бага	Үр дүн сөрөг
6.	Захиргааны шийдвэр гаргах	Энэхүү хувилбараар зорилгын тодорхой асуудлыг зохицуулж болох хэдий ч тэдгээр шийдвэрийн эрх зүйн байдлыг хуулиар тогтоогүй тул тодорхой хангалттай нөхцөл болж чадахгүй. Тухайлбал, төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх, төрийн цахим мэдээллийн сан, систем, сүлжээний эрх зүйн байдал, цахим засгийн үйл ажиллагааны нэгдсэн удирдлага, төлөвлөлт, зохицуулалтын тогтолцоо, түүний тогтвортой байдалтай холбоотой зорилгыг бүрэн шийдвэрлэж чадахгүй.	Зорилгын тодорхой хэсэг болох төрийн байгууллагын үйлчилгээг цахижуулах, цахим хэлбэрээр мэдээлэл солилцох харилцааг Засгийн газрын тогтоолоор зохицуулж байгаа ч эдгээр шийдвэрийн хэрэгжилт, үр өгөөж дутагдалтай байх талтай ба асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг бүрэн арилгаж чадахгүй	Үр дүн сөрөг
7.	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Энэхүү хувилбар нь зорилгыг бүрэн зохицуулах боломжтой	Тодорхой хэмжээний зардал гарах боловч үр өгөөж нь өндөр байна. Үр ашиггүй, давхардсан хөрөнгө оруулалт байхгүй болох, оновчтой, хариуцлагатай	Үр дүнтэй

			хөрөнгө оруулалт хийх, удирдлагын манлайлал, хариуцлага дээшлэх, засаглалын чадавхи, ил тод байдал, төрийн үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдэх нөхцлийг бүрдүүлнэ.	
--	--	--	---	--

Дээрх харьцуулалтаас харахад зөвхөн “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах” хувилбар үр дүнтэй харагдаж байна. Иймд хуулийн төслийн агуулга, зохицуулалтын хэлбэрийг өмнө тодорхойлсон Зорилгын дагуу дараах байдлаар ерөнхийлөн томъёолж байна:

“Тус хуулиар захиргааны байгууллагууд өөр хоорондоо болон иргэн, хуулийн этгээдтэй цахим хэлбэрээр харилцах, үйлчилгээ үзүүлэх, тэдгээрт шаардлагатай төрийн мэдээллийн сан, сүлжээ, систем, цахим баримт бичиг, цахим засгийн үйл ажиллагааны нэгдсэн удирдлага, үйл ажиллагааг зохицуулахтай холбогдсон харилцааг зохицуулна”.

## **ДӨРӨВ. СОНГОСОН ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ**

Аргачлалын 6-д заасны дагуу сонгосон хувилбарын үр нөлөөг тандан судалсан дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

*Жич: Хавсралт хэсэгт Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө, Эдийн засагт үзүүлэх үр нөлөө, Нийгэмд үзүүлэх үр нөлөө, Байгаль орчинд үзүүлэх нөлөө тус бүрийн асуултуудад хэрхэн хариулсныг оруулсан болно.*

### **4.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө**

Хуулийн төсөл боловсруулах хувилбар нь хүний эрхэд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй, харин хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөг өргөжүүлэх эерэг нөлөө үзүүлнэ.

### **4.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө**

Хуулийн төсөл боловсруулах хувилбар нь эдийн засагт сөрөг нөлөө үзүүлэхгүй, харин төрийн үйлчилгээ, үйл ажиллагааг боловсронгуй болгох, төрийн байгууллагуудын бүтээмж, үр ашигийг нэмэгдүүлэх боломж бүрдүүлсэнээр эдийн засгийн хөгжилд эерэг нөлөө үзүүлнэ.

Цахим засгийн хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой ямар нэг шинэ бүтэц, орон тоо бий болгох шаардлагагүй тул захиргааны нэмэлт зардал гарахгүй болно.

Харин төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, мэдээллийн санг цахимжуулах, мэдээллийн систем, сүлжээг хөгжүүлэхтэй холбоотой хөрөнгө оруулалтын зардлыг тухайн байгууллага төлөвлөх шаардлагатай. Эдгээр үйл ажиллагааг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр хэрэгжүүлэх боломжтой тул эдийн засгийн үр ашигтай хэлбэрийг сонгох хувилбар хууль, эрх зүйн хувьд нээлттэй.

Төрийн байгууллагууд цахим засгийн чиглэлээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрөө нэгдсэн удирдлага, төлөвлөлт, хяналтын арга хэлбэрээр хийх тул эдийн засгийн хэмнэлтийг төлөвшүүлэх боломжтой. Төрийн байгууллагуудын үйлчилгээ, үйл ажиллагааны цахимжихын хэрээр албан хаагчдын бүтцэд өөрчлөлт орох, албан хаагчдын орон тооны хэмнэлт бий болох боломжтой.

Төрийн байгууллагаас үйлчилгээ авах иргэн, хуулийн этгээдэд цаг хугацаа хэмнэх, төрийн байгууллагуудад хандахтай холбоотой 9000 төгрөгийн хэмнэлт гарна.

#### **4.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө**

Хуулийн төсөл боловсруулах хувилбар нь нийгэмд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй. Төрийн үйлчилгээ, үйл ажиллагаа боловсронгуй болсоноор нийгмийн хөгжилд эерэг нөлөө үзүүлнэ.

#### **4.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө**

Хуулийн төсөл боловсруулах хувилбар нь байгаль орчинд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй.

#### **4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх**

Хуулийн төсөл боловсруулах хувилбар нь Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрхийн талаарх Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа болно.

Мөн хуулийн төсөл боловсруулах хувилбар нь УИХ-аас 2016 онд баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” баримт бичгийн Дэд бүтцийн салбарын 7 дугаар зорилтыг хэрэгжилт, УИХ-ын 2011 оны 61 дүгээр тогтоолоор “төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхэд шаардлагатай хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” талаар Засгийн газарт үүрэг болгосон үүргийн хэрэгжилтлэлт, Засгийн газраас 2017 онд 47 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс мэдээлэл харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого 2017-2025” бодлогын баримт бичгийн 3.9.2. “цахим засгийн хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэх”, 3.9.3. “цахим засгийг тасралтгүй хөгжүүлэх тогтолцоог боловсронгуй болгож, хатуу болон зөөлөн дэд бүтэц, төрийн цахим үйлчилгээг нэгдсэн бодлоготой хөгжүүлэх”, 3.9.4. “төрийн цахим ой санамж болох мэдээллийн сан, өгөгдлийн бүрэн бүтэн, нэгдмэл, аюулгүй байдлыг хангаж нэг эх сурвалж бүхий мэдээлэл, нээлттэй өгөгдлийг бий болгож хөгжүүлэх”, 3.9.5. “иргэдэд

төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэхэд мэдээлэл, харилцаа холбооны дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн оролцоо, үйл ажиллагааг дэмжих”, 3.9.9. “монгол хүний хөгжлийг дэмжиж, эдийн засаг, нийгмийн дараах салбарт мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшил, инновацийг нэвтрүүлэх замаар хөгжлийг хурдасган бүтээмж, үр ашгийг дээшлүүлэх” гэсэн зорилттой тус тус нийцэж байгаа болно.

## **ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ**

Аргачлалын 7-д зааснаар хувилбарын эерэг болон сөрөг талуудыг зорилгод хүрэх байдал, зардал, үр өгөөжийн харьцаа, хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө, Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж буй эсэх гэсэн шалгуураар дахин нягталж үзэж, хууль тогтоомжийн төсөл боловсруулахдаа 2 дугаар хэсэгт тодорхойлсон зорилгыг хангах 3 дугаар хэсэгт ерөнхийлөн томъёолсон хуулийн төслийн агуулга, зохицуулах харилцааны хүрээнд цахим харилцааны тухай анхдагч хуулийн төсөл боловсруулж, асуудлыг шийдвэрлэх боломжтой гэж дүгнэлээ.

## **ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ**

Бусад орны эрх зүйн зохицуулалт, туршлагыг судлахдаа цахим засаг амжилттай хөгжсөн АНУ, БНСУ, Гүрж, Эстони улсыг сонгон авч холбогдох хууль тогтоомжийг нь судлав.

### **1. АНУ**

АНУ-д цахим засагтай холбоотой харилцааг Нууцын тухай хууль, Компьютерийн мэдээллийн нийцэл ба нууцлалын хамгаалалтын тухай хууль, Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, Компьютерийн аюулгүй байдлын тухай хууль, Онц дэд бүтцийн хамгаалалтын тухай хууль, Төрийн үйл ажиллагаанд цаасан суурьтай үйл ажиллагааг халах тухай хууль, Цахим засгийн тухай хууль гэсэн бүлэг хуулиудаар зохицуулж байна.

**Өгөгдөл хамгаалах тухай хууль.** Хувь хүний өгөгдөл, мэдээллийн хамгааллын харилцааг 1974 онд батлагдсан “Нууцын тухай хууль”-аар зохицуулсан ба хувь хүний өгөгдөлийг мэдээллийн эзний хүссэнээр тухайн үед, эсвэл бичгээр өмнө нь зөвшөөрлийн дагуу бусад байгууллагад өгөхөөр зохицуулж хамгаалсан. Түүнчлэн, өгөгдлийн эзний зөвшөөрөлгүйгээр хувь хүний өгөгдлийг боловсруулах үйл ажиллагаа, тэдгээрийг эрхлэх эрх бүхий субъектийг тогтоосон. Тухайлбал, Статистик мэдээлэл бүрдүүлэх зорилгоор Тооллогын бюро, хөтөлмөрийн статистикийн бюро, замын

харилцаа, архив, хууль сахиулах, Конгрессын судлагаа болон бусад захиргааны зорилгоор АНУ-ын холбогдох төрийн байгууллага хувь хүний өгөгдлийг эзнийх нь зөвшөөрөлгүйгээр боловсруулах эрх зүйн үндсийг тодорхойлсон.

**Компьютерийн мэдээллийн нийцэл ба нууцлалын хамгаалалтын тухай хууль.** “Компьютерийн мэдээллийн нийцэл ба нууцлалын хамгаалалтын тухай хууль”-аар “Нууцын тухай хууль”-аар хаалттай байсан мэдээлэл солилцох харилцаанд өөрчлөлт оруулах замаар төрийн болон төрийн бус байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох эрх зүйн үндсийг тогтоосон. Тус хуулийн зохицуулалтаар төрийн болон төрийн бус бусад байгууллагууд харилцан мэдээлэл солилцохдоо гэрээ байгуулах, уг гэрээнд мэдээлэл солилцох хүрээ, өгөгдлийн эзэд болон өгөгдөл хадгалагч байгууллагын ажилтнуудад мэдэгдэл хүргэх, мэдээлэл солилцсоны дараа мэдээллийг хадгалах, хамгаалах болон мэдээллийг бусдад дамжуулахгүй байх тухай тусгахаар хуульчилсан.

**Цаасан суурьтай ажлыг халах тухай хууль.** Цахим засгийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн энэхүү хууль 1998 онд батлагдсан бөгөөд компьютер, интернэтийн хэрэглээ иргэд, байгууллагуудын дунд түгээмэл хэрэглэгдэх болсон нөхцөл байдлыг харгалзан төрийн байгууллагуудаас үйлчлүүлэгчидтэй цахим хэлбэрээр харилцах, мэдээлэл солилцох, цаасан суурьтай харилцаанаас цахим хэлбэрт шилжих үйл явцыг хөхүүлэн дэмжих зорилт тавьсан агуулсан ба 2003 оноос төрийн бүх байгууллагууд цахим харилцаанд шилжих, тэрхүү харилцаандаа цахим гарын үсэг ашиглахыг үүрэг болгосон. Уг хуулийн зохицуулалтын дагуу төрийн үйлчилгээний маягыг цахимаар бөглөх, цахим баримт бичгийг хадгалах шаардлага тавигдсан ба цахим баримт бичиг, цахим гарын үсгийн хэрэглээний хууль эрх зүйн үндсийг бүрэн тодорхойлсон болно.

Figure 2: Federal Entities Involved in Establishing Governmentwide GPEA Guidance

Хуулиар зохицуулсан харилцааг хэрэгжүүлэхэд чиглэсэн журмыг АНУ-ын Ерөнхийлөгчийн Тамгийн газраас гаргахаар заасан ба уг журмаар төрийн байгууллагуудаас хууль хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлах, хуулийн хэрэгжилтийн талаархи тайлан гаргах, болон шаардлагатай бодлогыг арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг заасан. Уг журмын дагуу АНУ-ын Хууль зүйн газраас хуулийг хэрэгжүүлэх зөвлөмж, Төрийн сангийн газраас цахим төлбөр тооцоо, цахим хэлбэрээр адилтган танихтай холбоотой зөвлөмж, Худалдааны газраас төрийн мэдээлэл боловсруулах стандарт, Ерөнхий үйлчилгээний газраас хуулийн хэрэгжилттэй холбоотой хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөмж, Үндэсний архивын газраас төрийн мэдээллийн удирдлага болон цахим засгийн холбогдох баримт бичиг, мэдээллийг хадгалах бодлого, журам боловсруулах мөрдүүлэх чиг үүргийг тус тус өгсөн.

Түүнчлэн, төрийн байгууллагуудын зүгээс цахим баримт бичгийн хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангах, өөрчлөгдөхөөс сэргийлэх арга хэмжээ авахыг шаардсанаас гадна баталгаат гарын үсгийн хэрэглээг АНУ-ын дотоодод болон олон улсын харилцаанд ашиглахыг уриалсан (GAO Report to the Ranking Minority Member, Committee on Governmental Affairs, U.S. Senate).

**Цахим гарын үсгийн тухай хууль.** АНУ-ын цахим гарын үсгийн харилцааг зохицуулж буй хууль нь Конгрессоос 2000 онд баталсан “Олон улсын болон үндэсний цахим худалдаан ашиглах цахим гарын үсгийн тухай хууль” боловч нэгдсэн улсын бүрэлдэхүүний ихэнх улсууд өөр өөрсдийн хуультай байдаг. Уг хууль цахим баримт бичиг, цахим гарын үсгийн хэрэглээг дэмжихэд чиглэсэн ба аливаа гэрээ, хэлэлцээр нь цахим хэлбэрээр хийгдсэн гэсэн үндэслэлээ хууль зүйн чадамж ба үйлчлэлээ алдахгүй гэж тодорхойлсон байна. Энэ нь аливаа цахим баримт бичиг болон харилцаа нь цаасан суурьтай уламжлалт баримт бичиг, харилцааны нэгэн адил хүчинтэй гэдгийг хууль зүйн хувьд хүлээн зөвшөөрсөнөөрөө онцлог зохицуулалт болно.

**Цахим засгийн тухай хууль.** АНУ-ын Цахим засгийн тухай хуулийн (2002 он) гол үзэл санаа нь инноваци, технологийг үр ашигтай ашиглах замаар төрийн байгууллага иргэдэд үзүүлэх үйлчилгээгээ боловсронгуй болгох, хүнд суртлыг халж иргэн төвтэй, үр дүнд суурилсан, хариуцлагатай, нээлттэй, ил тод төрийн удирдлагын шинэ арга барилыг төлөвшүүлэх оршиж байна.

Хуулийн үндсэн зорилтыг доорхи байдлаар илэрхийлж болно. Үүнд:

- 1) АНУ-ын Удирдлага, Төсвийн газрын (Office of Management and Budget) бүрэлдэхүүнд Цахим засгийн хэрэг эрхэлсэн албаны бүтцийг бий болгох замаар төрийн үйлчилгээ, үйл ажиллагааг цахимжуулах, тэдгээрт дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий Цахим засгийн үр ашигтай манлайллын тогтолцоог бий болгосон;
- 2) Интернэт болон мэдээллийн технологид суурилсан бусад арга хэрэгслийг ашиглан иргэдийн зүгээс төрийн үйл ажиллагаанд оролцох боломжийг нээж өгсөн;
- 3) Иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх, тэдгээр үйлчилгээний нэгдмэл байдлыг бий болгох, төрийн байгууллагуудын үр ашигийг нэмэгдүүлэх чиглэлээр төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжих;
- 4) Төрийн байгууллагын зорилго, зорилтоо хүрэх боломжийг нэмэгдүүлэх;
- 5) Иргэн төвтэй мэдээлэл, үйлчилгээгээ хүргэхэд төрийн байгууллага дотооддоо болон байгууллага хоорондоо интернэт болон шинэ тутам гарч ирж буй технологийг ашиглах явдлыг дэмжих;
- 6) Төрийн үйлчилгээ авахаас үүдэлтэй бизнесийн байгууллага болон бусад байгууллагад үзүүлж зардал, хүндрэл чирэгдлийг бууруулах;



- 7) Улс төрчдөд мэдээлэлд суурилсан шийдвэр гаргахад нь дэмжлэг үзүүлэх;
- 8) Төрийн мэдээлэл, үйлчилгээг олон сувгаар өндөр чанартайгаар авах боломжийг бүрдүүлэх;
- 9) Мөрийн байгууллагуудын нээлттэй, ил тод, хариуцлагатай байх механизмыг бүрдүүлэх;
- 10) Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад байгаа сайн туршлагийг нэвтрүүлэх замаар төрийн үйл ажиллагааг өөрчлөн шинэчлэх;
- 11) Төрийн үйлчилгээний мэдээлэл, үйлчилгээг боловсронгуй болгох арга хэрэгсэл нь хувь хүний эрх, үндэсний аюулгүй байдлыг хангах, мэдээллийн хадгалалт хамгаалалтын чанарыг дээшлүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хандах боломжийг нэмэгдүүлсэн байх;

Хуулийн дээрх зорилтуудад хүрэхийн тулд холбооны агентлагуудад төрийн үйлчилгээгээ цахим засгийн хууль, тогтоомж, стандартын хүрээнд үйл ажиллагаа, үйлчилгээгээ цахимжуулах бодлого, журмаа тодорхойлох, төрийн нэгдсэн үйлчилгээний платформ, сувгийн үйл ажиллагаатай уялдуулан зохион байгуулах, үйлчилгээний чанар, бүтээмж, инновацид суурилсан технологи нэвтрүүлэлтийн гүйцэтгэлийн хэмжүүр тогтоох, бусад байгууллагуудтай үйл ажиллагаагаа уялдуулах харилцааг 202 дугаар хэсэгт тодорхойлсон.

Цахим үйлчилгээ, харилцаанд баталгаат цахим гарын үсэг ашиглах зохицуулалтыг 203 дугаар хэсгээр, төрийн үйлчилгээний Холбооны нэгдсэн порталын эрх зүйн байдлыг 204 дүгээр хэсгээр, төрийн мэдээллийн хүртээмж, ашиглалт, хадгалалттай холбоотой харилцааг 207 дугаар хэсгээр, иргэдийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлын хамгаалалттай холбоотой харилцааг 208 дугаар хэсгээр, төрийн албан хаагчдын мэдээллийн технологийн чадавхийг бүрдүүлэх харилцааг 209 дүгээр хэсгээр, төрийн тусгай чиг үүргийн байгууллага, тухайлбал, шүүх эрх мэдлийн байгууллагууд болон зохицуулах чиг үүргийн байгууллагуудын цахим засгийн харилцааг 206 болон 207 дугаар хэсгээр тус тус зааж тодорхойлж өгсөн.

Дээрх зохицуулалтаас гадна АНУ-ын цахим засгийн тогтолцоог 36 дугаар бүлгийн 3601-3606 дугаар зүйлээр тодорхойлж Цахим засгийн ажлын алба (3602 дугаар зүйл), төрийн мэдээллийн технологийн албан хаагчдын консул (3603), цахим засгийн хөгжлийн сангийн харилцаа (3604 дүгээр зүйл), төрийн үйл ажиллагаанд инноваци нэвтрүүлэх харилцаа (3605 дугаар зүйл), цахим засгийн нэгдсэн тайлантай холбоотой харилцааг (3606 дугаар зүйл) тус тус зохицуулсан байна.

Түүнчлэн, мэдээллийн аюулгүй байдал, мэдээллийн нууцлал, хамгаалалтын харилцааг онцгойлон авч үзэж таван зүйл бүхий 3 дугаар бүлэг, гурван зүйл бүхий 4 дүгээр бүлгийн заалтуудаар зохицуулсанаас гадна статистик мэдээний бүрдүүлэлт,

ашиглалтыг 5 дугаар бүлгийн 521-526 дугаар хэсгээр, төр, хувийн хэвшлийн түншлэлийн “Мэдээллийн технологийн солилцооны хөтөлбөр”-ийн харилцааг 37 дугаар бүлгийн 3701-3707 дугаар хэсгээр тус тус зохицуулжээ.

## **2. БНСУ**

**Үндэсний мэдээлэлжүүлэлтийн тухай хууль.** БНСУ “Үндэсний мэдээлэлжүүлэлтийн тухай хууль”-ийг 1995 онд анх батласан бөгөөд 2017 оны 1 дүгээр сарын байдлаар 50 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан. Хуулийн зорилгыг мэдлэг, мэдээлэлд суурилсан тогтвортой нийгмийг бий болгоход чиглэсэн харилцааг зохицуулах, үндэсний мэдээлэлжүүлэлтийн ерөнхий чиглэл, бодлогыг тодорхойлох үйл ажиллагааг хэрэгжүүлэх замаар улс орны амьдралын чанарыг дээшлүүлэх явдал гэж тодорхойлсон.

Хуулиар төрийн болон нутгийн захиргааны байгууллагууд үндэсний мэдээлэлжүүлэлтийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, тэдгээр төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ хувийн хэвшлийн оролцоог хангаж ажиллах эрх зүйн үндсийг бүрдүүлсэнээс гадна БНСУ-ын хэмжээнд үндэсний мэдээлэлжүүлэлтийн ерөнхий төлөвлөгөөг 5 жилийн хугацаатайгаар боловсруулах, хэрэгжүүлэх, харилцан уялдааг хангах чиг үүргийг Шинжлэх ухаан, мэдээлэл, холбоо, ирээдүйн төлөвлөлтийн яам хариуцахаар зохицуулсан.

Хуулийн хэрэгжилтийг хангах зохицуулалтын хүрээнд үндэсний мэдээлэлжүүлэлтийн хөтөлбөрийн хэрэгжилт хариуцсан албан тушаалтныг томилохыг бүх шатны төрийн байгууллага үүрэг болгосноос гадна тэрхүү албан тушаалтны чиг үүрэг, үйл ажиллагааг зааснаа гадна аливаа төрийн байгууллага нь томоохон хэмжээний төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхдээ мэдээлэлжүүлэлтийн хөтөлбөрийн хэрэгжүүлэх бүрдэлтэй байхаар зохицуулсан.

Хуулиар төрийн байгууллагуудын мэдээлэлжүүлэлтийн хөтөлбөрийн хэрэгжилтийн харилцан уялдаа, нэгдмэл байдлыг хангах, техник, технологийн шийдлийн дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий Үндэсний мэдээллийн нийгмийн агентлаг (National Information Society Agency, NIA) байгуулахаар зааж уг байгууллагын үйл ажиллагааг нарийвчлан зохицуулсан.

Түүнчилэн, хуулийн зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэсэн нийгмийн харилцаанд оролцогч төр, олон нийт, хувийн хэвшил, сонирхлын бүлгүүдийн түвшинд мэдээлэлжүүлэлтийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, мэдлэг мэдээллийг хуваалцах, түгээх, хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэлжүүлэлтийн үйл ажиллагааг дэмжсэн харилцаа холбооны сүлжээг хамтран ашиглах, мэдээллийн сүлжээгээр дамжуулан мэдээлэл хуваалцах үйл ажиллагааг дэмжих, өгөгдөл

мэдээллийн нэгдсэн төв байгуулах, мэдээлэл болон интернэтийн орчины хэрэглээний соёлыг төлөвшүүлэх, зөв зохистой хэрэглээг дэмжих болон гэрчилгээжүүлэх, тоон ялгааг арилгах, олон улсын түвшинд идэвхитэй үйл ажиллагаа явуулах зэрэг өргөн хүрээний харилцааг зохицуулсан.

**Цахим баримт бичиг, цахим харилцааны тухай хууль.** Тус хуулийн зорилго нь цахим баримт бичиг, цахим харилцааны эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээрийн аюулгүй байдлыг хангах дэд бүтцийн харилцааг зохицуулсан ба НҮБ-ын цахим худалдааны загвар хуулийн нийцэлтэй хууль болсон.

Цахим баримт бичгийн эрх зүйн байдлыг хуульд өөрөөр заагаагүй бол аливаа цахим баримт бичиг нь цахим хэлбэртэй байсан гэсэн үндэслэлээр хууль зүйн хүчинтэй байдлаа алдахгүй гэж тодорхойлсоноос гадна цахим баримт бичгийг хадгалах шаардлага болон илгээх, хүлээн авах талаархи субъектуудын харилцааг нарийвчлан зохицуулсан байна.

Цахим баримт бичгийг баталгаажуулах харилцааг “Цахим гарын үсгийн тухай хууль”-аар зохицуулахаар заасан.

**Цахим засгийн тухай хууль.** БНСУ цахим засгийн харилцааг зохицуулсан “Цахим засгийн тухай хууль”-ийг анх 2001 онд батлаж байсан ба хуулийн шинэчилсэн найруулгыг 2010 оноос батлан мөрдөж байна. Энэхүү хуулийн үндсэн зорилгыг нь цахим засгийн үр ашигтай хэлбэрийг дэмжих, төрийн захиргааны бүтээмж, ил тод байдлыг өргөжүүлэх, төрийн ардчиллыг хөгжүүлэх, захиргааны байгууллагын үйл ажиллагааны цахим хэлбэрээр явуулахад шаардлагатай үндсэн зарчим, процедур, дэмжлэгийн арга замыг тодорхойлох замаар иргэдийн амьдралын чанарыг сайжруулна гэж заасан байна. Тус хууль цахим засгийг мэдээллийн технологийн тусламжтай захиргааны байгууллагуудын хоорондын үйл ажиллагааг үр ашигтайгаар зохицуулах болон иргэнд үзүүлж буй захиргааны байгууллагын үйлчилгээг цахимжуулах гэж тодорхойлсон.

Хуулийн зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэсэн төрийн үйлчилгээг цахимжуулах, иргэдэд үзүүлж буй үйлчилгээний ая тухтай байдлыг дээшлүүлэх, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд инноваци нэвтрүүлэх, бүтээмж, үр ашигийг нэмэгдүүлэх, төрийн мэдээллийн системийн аюулгүй байдал, найдвартай ажиллагаа, хувийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, төрийн мэдээллийг харилцан солилцох үйл ажиллагааг өргөжүүлэх, давхардсан хөрөнгө оруулалтаас урьдчилан сэргийлэх, болон техник технологийн харилцан нийцтэй байдлыг хангах зарчмыг тодорхойлж тэдгээрийг хангах доорхи үндсэн зохицуулалтыг тодорхойлж өгсөн. Үүнд:

1. Цахим засгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, түүний бүрэлдэхүүн (5 зүйл);

2. Иргэдийн өргөдөл, гомдлыг цахим хэлбэрээр авах нөхцөл, шаардлага (7 дугаар зүйл);
3. Төрийн цахим үйлчилгээ, тэдгээрийн жагсаалт (12-4 дугаар зүйл);
4. Төрийн цахим үйлчилгээний төлбөр, тооцооны зохицуулалт (13 дугаар зүйл);
5. Цахим нэг цонхны эрх зүйн байдал, түүний үйл ажиллагаа (20 дугаар зүйл);
6. Цахим баримт бичиг, түүний солилцох ажиллагаа (3 дугаар бүлэг);
7. Төрийн мэдээлэл солилцооны зангилаа, түүний эрх зүйн байдал (30-3 дугаар зүйл);
8. Төрийн мэдээлэл солилцох үйл ажиллагааны харилцаа, зохицуулалт (4 дүгээр бүлэг);
9. Иргэн өөрт хамаарах мэдээлэлд хандах хүсэлт, түүний зохицуулалт (42 болон 43 ыдугаар зүйл);
10. Төрийн мэдээллийн технологийн дэд бүтэц, систем, сүлжээний архитектур, тэдгээртэй холбоотой харилцаа (5 дугаар бүлэг);

### **3. Эстони улс**

Эстони улс цахим засгийн үйл ажиллагаа, харилцааг “Нийтийн мэдээллийн тухай хууль”-аар (2001) харин интернэт ба мэдээлэлжсэн нийгмийн харилцааг “Архивын тухай хууль” (1998), Electronic Identification and Trust Services for Electronic Transactions Act (2016) гэсэн хууль, эрх зүйн баримт бичгүүдээр тус тус зохицуулж байна.

Эстони улсын “Нийтийн мэдээллийн тухай хууль”-аар нийтийн мэдээлэлд хандах боломжийг иргэн, хуулийн этгээдэд олгох, төр болон олон нийтийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавих боломжийг бүрдүүлэх зорилготойгоор анх 2001 онд батласан ба 2019 оны 3 дугаар сарын 15-ны байдлаар нийт 36 удаагийн нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

Энэ хуулийн үндсэн концепци нь нийтийн мэдээлэл (public information), түүнд хандах, дахин ашиглах, тэдгээрийн зохион байгуулалт, мэдээлэл эзэмшигчийн үүргийг хуульчилсанаас гадна уг хууль бүхэлдээ дата засаглал бүрдүүлэхэд чиглэсэн харилцааг зохицуулсан хууль юм. Түүнчлэн, уг хууль нь мэдээллийн ил тод байдлын тухай, мэдээлэл авах эрхийн тухай, төрийн болон албаны мэдээллийн нууцлал, түүнд хандах эрхийн тухай, нээлттэй өгөгдөл бий болгох, цахим засгийн харилцааны технологийг үндэс суурь болсон мэдээллийн сан, систем, тэдгээрийн чиг үүрэг, үйл ажиллагааг зохицуулсан дүрэм, журмын эрх зүйн үндсийг тогтоож өгсөн.

Нийтийн мэдээллийг хууль, тогтоомжоор олгосон чиг үүргийн хүрээнд аливаа боломжит аргаар дурын хэрэгсэл дээр үүсгэн баримтжуулсан мэдээллийг хэлнэ гэж тодорхойлон түүнд хандах хандалтыг зөвхөн хуульд заасны дагуу хязгаарлаж болно гэж зохицуулсан (3 дугаар зүйл).

Нийтийн мэдээллийг дахин ашиглах (re-use of public information) гэдэгт дараах үйл ажиллагааг ойлгохоор тусгасан (3<sup>1</sup> дугаар зүйл):

- Нийтийн мэдээлэл эзэмшигчийн мэдээллийн анхдагч зориулалтаас нь өөр ашгийн болон ашгийн бус зорилгоор хувь, хуулийн этгээд ашиглах эрх (нээлттэй мэдээллийн зохицуулалт). Энэ тохиолдолд төрийн болон олон нийтийн чиг үүрэг хэрэгжүүлэх зорилгоор мэдээлэл солилцох харилцааг олон нийтийн мэдээллийн дахин ашиглалт гэж үзэхгүй байх;
- Нийтийн мэдээлэл эзэмшигч нь аль нэг субъекттэй нийтийн мэдээллийн дахин ашиглах дагнасан гэрээ байгуулахгүй байх шаардлага;
- Нийтийн мэдээллийг дахин ашиглах ажиллагаа нь хувь хүний эрх, зохиогчийн эрх, үндэсний аюулгүй байдал, байгууллагын нууц болон хуулиар хязгаарласан мэдээллийн нууцлалыг зөрчихгүй байх шаардлага;
- Нийтийн мэдээлэл эзэмшигч нь компьютерт уншигдах форматаар нийтийн мэдээллийг нээлттэй болгох, түүнд хандах боломжоор хангах шаардлага;
- Нээлттэй болгох мэдээлэл нь хувь хүний өгөгдөл, мэдээлэл агуулахгүй байх шаардлага;
- Өөрт хамаарах мэдээллээ нээлттэй болгох, эс болгох талаар хувь хүний сонголтыг хүндэтгэх нөхцөл;
- Нээлттэй мэдээлэл бий болгох талаар Засгийн газрын болон эрхэлсэн сайдын чиг үүрэг;
- Өрсөлдөөнд үл харшлах нөхцлөөр нийтийн мэдээллийг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр нээлттэй болгох нөхцөл;

Нийтийн мэдээлэл бүрдүүлэх эрх бүхий субъектэд Эстони улсын хууль, тогтоомжоор иргэд, хуулийн этгээдийн бүртгэл хөтлөх эрх бүхий бүх шатны төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллага, мөн бусад хууль, тогтоомжоор эрх олгогдож олон нийтийн үйлчилгээ эрхэлж буй иргэн, хуулийн этгээдийг хамаарч байна.

“Нийтийн мэдээллийн тухай хууль”-ийн зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэсэн дараах үндсэн харилцааг уг хуулиар зохицуулж өгсөн. Үүнд:

1. Мэдээлэл эзэмшигч (5 дугаар зүйл), түүний үүрэг (2, 3, 5 дугаар бүлэг, тэдгээрийн харгалзах зүйл, ангиуд);
2. Мэдээлэл авах хүсэлт (6 дугаар зүйл), түүнийг хэрэгжүүлэхэд мэдээлэл эзэмшигчийн үүрэг (2, 3, 5 дугаар бүлэг, тэдгээрийн харгалзах зүйл, ангиуд);
3. Мэдээлэл авах хүсэлт гаргасан этгээд (7 дугаар зүйл);
4. Мэдээлэлд хандах хандалт (8 дугаар зүйл), түүнийг хэрэгжүүлэх арга, механизм, мэдээлэл эзэмшигчийн үүрэг (2, 3, 5, 5<sup>1</sup> дугаар бүлэг, тэдгээрийн харгалзах зүйл, ангиуд);

5. Мэдээллийн сан (5<sup>1</sup> дугаар бүлэг), түүнийг удирдах систем, төрийн үйлчилгээний цахим үйлчилгээний нэгдсэн портал, төрийн мэдээллийн систем, мэдээлэл солилцооны систем, эдгээр системийг дэмжих туслах дэд системийн зохицуулалт;

“Нийтийн мэдээллийн тухай хууль”-ийн дагуу нийтийн мэдээлэлд хандах хандалтын төлбөр, хураамжтай холбоотой харилцааг дараах байдлаар зохицуулсан:

- хууль, тогтоомжоор тогтоосноос бусад мэдээлэл үнэ төлбөргүй байх (4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг);
- нийтийн мэдээлэл нь үнэ, төлбөртэй бол мэдээлэлд хандах хандалтын нөхцөл, төлбөр, хураамжийн хэмжээ, түүнийг тогтооход зардлыг тооцсон байдлыг ил тод байлгах (4 дүгээр зүйлийн 4<sup>1</sup> дэх хэсэг);
- Мэдээлэл эзэмшигч хуулиар тогтоосон чиг үүргээс өөр зориулалтаар бусад байгууллагын нийтийн мэдээлэлд хандаж байгаа бол мэдээлэлд хандагч бусад этгээдтэй ижил нөхцлийг мөрдөж, төлбөр хураамж төлөх (4 дүгээр зүйлийн 4<sup>3</sup> хэсэг);

Эстони улс “Нийтийн мэдээллийн тухай хууль”-даа мэдээллийн сан бүрдүүлэх, харилцааг 2007 оны нэмэлт, өөрчлөлтөөс эхлэн тусгасан ба дараа, дараагийн нэмэлт, өөрчлөлтүүдээр мэдээллийн сангийн удирдлага, хяналт, төрийн мэдээллийн систем, тэдгээрийн бүрэлдэхүүн, үүрэгтэй холбоотой зохицуулалтыг 2008 оны нэмэлт, өөрчлөлтөөр Мэдээллийн сан гэсэн 5<sup>1</sup> бүлгийг бий болгосон.

Мэдээллийн сан, мэдээллийн системтэй холбоотой дараах онцлог зохицуулалтууд байна. Үүнд:

1. Төрийн байгууллага мэдээллийн санг зөвхөн хуульд заасан үндэслэлээр байгуулах;
2. Нэг ижил мэдээллээр тусдаа мэдээллийн сан үүсгэхийг хоригдох (single source);
3. Мэдээллийн сан байгуулах нөхцөл, шаардлагыг тогтоож, уг шаардлагын хэрэгжилтийн хүрээнд Эстони улсын Мэдээллийн системийн газраас баталгаажуулсны үндсэн дээр байгуулах үйл ажиллагаа явуулах;
4. Мэдээллийн сангийн удирдлага, дата засаглалын нөхцөл, шаардлагыг тодорхойлох, мөрдүүлэх;
5. Мэдээллийн сангийн удирдах системийн технологийн нийцлийн зохицуулалт, шаардлага;
6. Мэдээллийн сангийн дүрэм, түүнийг бүрдүүлэх субъект;
7. Анхдагч мэдээлэл, түүнийг үл давтах нөхцөл;

8. Мэдээллийн сангийн бүртгэл, техникийн нөхцөл, шаардлага, зохицуулах журам;
9. Төрийн мэдээллийн сангийн ашиглалт, мэдээлэл харилцан солилцох шаардлага, нөхцөл;
10. Мэдээллийн сангийн өгөгдөлд хандах нөхцөл, аюулгүй байдлын хамгаалалт зэрэг өргөн харилцааг зохицуулсан.

Түүнээс гадна “Нийтийн мэдээллийн тухай хууль”-д төрийн мэдээллийн систем, төрийн мэдээллийг дэмжих систем, тэдгээрт тавигдах нөхцөл, шаардлагыг “Мэдээллийн сан” гэсэн 5<sup>1</sup> бүлэгт тодорхойлсоноос гадна вэбсайт, мобайл програм хөгжүүлэх, ашиглах, тэдгээрийг төрийн үйл ажиллагаа, үйлчилгээнд ашиглах нөхцөл, шаардлага, тогтвортой ажиллагааны зарчмыг “Нийтийн дата сүлжээнд мэдээллийг нээлттэй болгох” гэсэн дэд бүлэгт тодорхойлж өгсөн байна.

## **ДОЛОО. ЗӨВЛӨМЖ**

Энэхүү тандан судалгааны 2 дугаар хэсэгт томъёолсон зорилгод хүрэхийн тулд 3 дугаар хэсэгт /анхдагч/ хуулийн төсөл боловсруулах шаардлагатай нь тогтоогдож, уг хуулиар зохицуулах харилцааг тус хэсэгт ерөнхийлөн тодорхойлсон.

Мөн 4 дүгээр хэсэгт хуулийн зохицуулалтын хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг судлахад сөрөг нөлөө гараагүй бөгөөд 5 дугаар хэсэгт зохицуулалтын хувилбарыг өмнөх шатуудад хийсэн судалгааны хүрээнд харьцуулан дүгнэхэд хуулийн төсөл боловсруулж, зохицуулах нь зүйтэй гэсэн дүгнэлт гарсан.

Иймд 6 дугаар хэсэгт гадаад орнууд /АНУ, БНСУ, Эстони/-ын хуулийн зохицуулалтыг судалж, цахим засгийн анхдагч хуулиар дараах асуудлыг нарийвчлан зохицуулах нь зүйтэй гэсэн зөвлөмжийг гаргаж байна:

1. Захиргааны байгууллагууд өөр хоорондоо болон иргэн, хуулийн этгээдтэй цахим хэлбэрээр харилцах, үйлчилгээ үзүүлэх зорилтын хүрээнд:

1.1. Захиргааны байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд үзүүлдэг үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлж болох эрх зүйн үндсийг тодорхойлж өгөх;

1.2. Иргэн, хуулийн этгээдэд үзүүлдэг үйлчилгээнд шаардлагатай бусад байгууллагаас авах мэдээллийг цахим мэдээлэл солилцооны системээр дамжуулан авах талаар зааж өгөх;

1.3. Захиргааны байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд хандан явуулах албан бичгийг цахим хэлбэрээр явуулж болохыг тодорхойлох;

1.4. Захиргааны байгууллага албан харилцаандаа цахим шуудан ашиглаж болох зааж өгөх;

2. төрийн мэдээллийн сан, сүлжээ, систем, цахим баримт бичгийн эрх зүйн байдлыг тодорхойлох зорилтын хүрээнд:

2.1. Төрийн цахим харилцааны үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа суурь системүүд, захиргааны байгууллагуудын мэдээллийн сан, системийн эрх зүйн байдлыг тодорхойлох тэдгээрийг хөгжүүлэх, ашиглалт, үйлчилгээ хариуцах байгууллагын чиг үүргийг тодорхойлох;

2.2. Цахим засгийн суурь үйл ажиллагааны гол чиглэл болох төрийн цахим мэдээлэл солилцох үйл ажиллагаа, таньж нэвтрүүлэх үйл ажиллагаа (Single Sign on), цахим баримт бичгийн солилцох үйл ажиллагаа, цахим архив, эргэн мэдээлэх үйл ажиллагаа, албаны цахим шуудан, төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал, иргэдийн оролцоог хангах үйл ажиллагааны эрх зүйн байдлыг тодорхойлох, тэдгээр үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх үндсэн чиглэлийг тодорхойлох;

2.3. Захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд ашиглаж буй мэдээллийн сан, систем, сүлжээний эрх зүйн байдлыг тодорхойлох, тэдгээрийн хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангах шаардлагыг зааж тодорхойлох;

3. Цахим засгийн талаархи төрийн байгууллагуудын чиг үүргийг тодорхойлох зорилтын хүрээнд:

3.1. Цахим засгийн талаар Захиргааны байгууллагуудын ерөнхий чиг үүргийг тодорхойлох, тэдгээр байгууллагын иргэд, хуулийн этгээдэд үзүүлж буй цахим хэлбэрийн үйлчилгээ нь суурь үйл ажиллагааны системд холбогдох шаардлагыг зааж өгөх;

3.2. Цахим засгийн хөгжлийн талаар Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Тагнуулын ерөнхий газар, Үндэсний дата төв УТҮГ-ын хариуцах чиг үүргийг тодорхойлох;

4. Төрийн нээлттэй өгөгдлийг хөгжүүлэх зорилтын хүрээнд:

1.1. Захиргааны байгууллагууд хуулиар хориглоогүй мэдээллийг нээлттэй болгох эрх зүйн үндсийг бүрдүүлэх зохицуулалтыг тусгах;

1.2. Нээлттэй өгөгдлийг хөгжүүлэх үндсэн чиг үүргийг хариуцсан Захиргааны байгууллагыг тодорхойлох;

5. Цахим засгийн нэгдсэн удирдлага, төлөвлөлт, хяналтын тогтолцоо бүрдүүлэх зорилтын хүрээнд:

1.3. Цахим засгийн үйл ажиллагааны тогтвортой, тасралтгүй байдлыг хангахад чиглэсэн бодлого, үйл ажиллагааг тогтоох чиг үүрэг бүхий Цахим засгийн бодлогын зөвлөлийг байгуулах, төлөөллийг төрийн захиргааны төв болон захиргааны байгууллагын удирдах, шийдвэр гаргах түвшиний төлөөллөөс бүрдүүлэх эрх зүйн үндсийг тодорхойлох;

1.4. Уг Зөвлөлөөс гарсан шийдвэрийн хэрэгжилтийг холбогдох байгууллага эргэж тайлагнадаг байх зохицуулалт тусгах;

1.5. Зөвлөлийн Ажлын алба, түүний чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллагыг тогтоох;

1.6. Захиргааны байгууллагын цахим засгийн асуудал эрхэлсэн нэгж, бүтцийг Цахим засгийн тогтолцоонд багтаах зохицуулалт тусгах;

1.7. Захиргааны байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний цахимжуулалт цахим засгийн техник, технологийн хөгжүүлэлтийн төсөл, хөтөлбөрийг Цахим засгийн Ажлын албаар хянуулж, баталгаажуулах асуудлыг зохицуулах.



## ХАВСРАЛТ

### Хүснэгт 1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	<b>1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх</b>			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	<b>1.2. Оролцоог хангах</b>			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	<b>1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага</b>			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхүүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй	
2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Эрх агуулагч	3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

## Хүснэгт 2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр	Тийм	Үгүй	Цахим засгийн зарим чиг үүргийг

болон захиргааны зардал	аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх			хэрэгжүүлж буй аж ахуйн нэгжүүдэд техник, технологи, хүний нөөцийн зардал гарна.
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Үгүй	Хуулийн этгээдээс ямар нэг зардал гарахгүй, харин эсрэгээр төрийн үйлчилгээ авахтай холбоотой эдийн засгийн хэмнэлт бий болно.
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид)	Тийм	Үгүй	Иргэний санхүүгийн байдалд эерэг

	нөлөө үзүүлэх эсэх			нөлөө үзүүлнэ.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	<b>Тийм</b>	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	<b>Тийм</b>	Үгүй	Жижиг дунд үйлдвэр хөгжихэд шаардлагатай төрийн үйлчилгээнээс үүдэлтэй эерэг орчин бүрдэнэ.
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	<b>Тийм</b>	Үгүй	Улсын төсөвт тодорхой хэмжээний нөлөө үзүүлнэ.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	<b>Тийм</b>	Үгүй	Зарим төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийнэ.
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	<b>Тийм</b>	Үгүй	Төрийн байгууллага нь энэ хуулиар тодорхой чиг үүрэг хүлээж ажиллана.
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	<b>Тийм</b>	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Тийм	<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	<b>Тийм</b>	Үгүй	Зөрчилдөхгүй

### Хүснэгт 3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	<b>Тийм</b>	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Тодорхой ажлын мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр	<b>Тийм</b>	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх			
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

байдал	баралтын байдалд нөлөөлөх эсэх			
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Төрийн мэдээлэл, үйлчилгээ сайжирсанаар нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд эерэг нөлөө үзүүлэх болмжтой. Сөрөг нөлөө байхгүй.
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	үзүүлэх эсэх			
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

#### Хүснэгт 4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй